



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТЫН НЭР: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл
ажиллагааны үр ашиг**

АУДИТЫН КОД: АГГ-2022/22-ШТА-ГА

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ
АЛДАГДАЛТАЙ, ХЯНАЛТ НЬ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА**

Баян-Өлгий аймаг 2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:

М.Хуанган

Утас: 70422954 цахим хуудас:

Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 цахим хуудас:

jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291

ainurm@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 999427301

Цахим хуудас: nazguld@audi.gov.mn

Аудитор Р.Баярмаа

Аудитор С.Нурлан

Утас: 99265539, 94209011

Цахим хуудас: Bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН	Error! Bookmark not defined.
ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ АЛДАГДАЛТАЙ,	Error! Bookmark not defined.
ХЯНАЛТ НЬ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА	Error! Bookmark not defined.
АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёо.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ҮР ДҮН НӨЛӨӨГҮЙ БАЙНА	8
1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй байна.....	8
1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль нь компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна	8
1.1.2 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх тусгайлсан зарчим, аргачлал байхгүй байна	8
1.1.3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд арга хэмжээ төлөвлөөгүй, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлээгүй байна.....	9
1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт хангагдаагүй байна	10
1.2.1. Төрийн эрх бүхий байгууллагаас орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх тогтвортой бодлого баримталж ажиллаагүй байна	10
1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилт хангагдаагүй байна	12
1.2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт хүргэх нөхцөл бүрдээгүй байна	13
1.2.4. Орон нутгийн хуулийн этгээдийн эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага болон ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөөгүй байна	15
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА	17
2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага нь хянаж батлаагүй байна.....	17
2.1.1. “Суат” ХХК-ны эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж, батлуулаагүй байна	17
2.1.2. Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага хянаж батлах асуудал дутагдалтай байна	19
2.2. “Суат” ХХК-ны орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, ЦШСГ орлогын бүрдүүлэлт зорилтот түвшнийг хангаж ажилласан байна	21
2.2.1. Суат” ХХК төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй, ЦШСГ худалдан борлуулсан цахилгаан эрчим хүчний орлогын дундаж барагдуулалт 98.8 хувьтай байна	21
2.2.2. “Суат” ХХК төсөвт төвлөрүүлэх татварыг хугацаанд төвлөрүүлээгүйгээс 234.5 сая төгрөгийн он дамжсан өр үүсгэсэн байна.....	24
2.3. “Суат” ХХК-ны үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаагүй, үр ашиггүй байна	26
2.3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүй байна	26
ЦШСГ нь санхүүгийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдээр санхүүгийн шинжилгээг бодитой хийгээгүй, үйл ажиллагаагаа төлөвлөх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.	32
2.3.2. Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд санхүүгийн шинжилгээ, үр ашгийн тооцоо хийж, дүгнэж ажиллаагүй байна	33
2.3.3. Шууд гэрээгээр худалдаж авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчиж, ашиг сонирхол бүхий гэрээ хийж ирсэн байна	33
2.4. Санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна	33
2.4.1. Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөөгүй, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна	33
2.4.2. Үйл ажиллагааны зардлын төлөвлөлт оновчгүй байна.....	36
2.4.3. Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагадаа үндэслэж төлөвлөөгүй байна	41
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА	41
3.1. Дотоод аудитын хяналт шалгалт үр нөлөөгүй байна	41

3.1.1. Орон нутгийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын албанаас хийсэн хяналт хангалтгүй байна.....	41
3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна.....	42
3.2.1. Удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй байна	42
3.2.2. Удирдлагын дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.....	43
3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангуулж ажиллаагүй	46
3.3.1 Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаатай байна.....	46
3.3.2. Үйл ажиллагааны мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод, нээлттэй мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	46
ДҮГНЭЛТ:.....	48
ЗӨВЛӨМЖ:.....	49
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	51

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ББЭХ	Баруун бүсийн эрчим хүч
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэр газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн газар
СХЗХ	Стандарт хэмжилзүйн хэлтэс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХХАТ	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
ЦТС	Цахилгаан түгээх станц

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1	Түгээх цахилгааны мэдээ судалгаа	18
Хүснэгт 2	Борлуулалтын орлогын судалгаа	19
Хүснэгт 3	Орлогын төлөвлөлт	21
Хүснэгт 4	Цэвэр усны хэрэглэгчийн судалгаа	22
Хүснэгт 5	Санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	24
Хүснэгт 6	Өр төлбөрийн судалгаа	24
Хүснэгт 7	Үйл ажиллагааны шинжилгээ	26
Хүснэгт 8	Орлогын тайланд хийсэн шинжилгээ	27
Хүснэгт 9	Харьцааны шинжилгээ	28
Хүснэгт 10	Аудитын шинжилгээ	30
Хүснэгт 11	Харьцааны шинжилгээ	31
Хүснэгт 12	Удирдлагын зардлын судалгаа	34
Хүснэгт 13	Бизнес санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	35
Хүснэгт 14	Үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл	37
Хүснэгт 15	Цалин урамшуулал, орон тооны судалгаа	40

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ✓ Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх; ✓ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх; ✓ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	“Суат” ХХК, Цахилгаан шугам сүлжээний газрын 2019-2021 оны үйл ажиллагаа, бизнес санхүүгийн төлөвлөгөө, түүний биелэлт, статистик мэдээ, техник эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад материалуудыг хамруулсан.
Аудитын хязгаарлалт	Байхгүй
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ҮАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, Д.Назгүл, аудитор Р.Баярмаа, С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 06 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ҮАГ-ын Аудитын гуравдугаар газарт хүргүүлэхээр төвлөж ажиллав.

Хүндрэл бэрхшээл

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ҮР ДҮН НӨЛӨӨГҮЙ БАЙНА

1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй байна

1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль нь компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах зэрэг зөвхөн эд хөрөнгийн эрхийг заасан бөгөөд хуульд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаар заалт тусгагдаагүй байгаа нь компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

Компанийн тухай хуулийн 2, 75, 76, 79, 80, 81, 82 83, 84 дүгээр зүйлд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороо, ТУЗ-ийн хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж, компанийн засаглалын тогтолцооны бүрэлдэхүүн гүйцэтгэх удирдлага, эрхий бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн эрх үүрэг, оролцоог тодорхойлсон байна.

Харин компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод байдалтай холбоотой асуудал бүрэн тусгагдаагүй байна.

1.1.2 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх тусгайлсан зарчим, аргачлал байхгүй байна

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам” нь холбогдох хуулийг дагаж мөрдүүлэх, компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх, засаглалын түвшнийг сайжруулах зорилгоор үнэлгээ хийх, түвшнийг тогтоох, түүнийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах, компанийн сайн засаглалын тогтолцоог бий болгоход чиглэгджээ.

Компанийн засаглалын бодлогыг боловсруулахад Удирдах зөвлөл чухал үүрэг гүйцэтгэдэг. Стратегийн зорилгыг тодорхой болгохын тулд бизнесийн менежменттэй холбоотой байх шаардлагатай. Тодорхой стратеги боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь байгууллагын амжилтад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-т “төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн засаглал болон чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна” гэж заажээ.

ТУЗ-ийн үйл ажиллагаа нь компанид хамтын удирдлагыг хэрэгжүүлдэг дээд байгууллага тул ТУЗ-ийн дэргэдэх дэд хороонууд компанийн тухай хуульд зааснаар хуралдаж ажлаа хийдэг байх нь чухал учраас ТУЗ-ийн гишүүдэд бизнес процесст чиглэсэн тогтмол сургалт, зөвлөгөө хэрэгтэй байгаа юм.

Журмын 3.2¹-т нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр, 3.3.3²-т ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр засаглалын үнэлгээ хийх тухай заасан нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх эрх зүйн зохицуулалтгүй байна.

Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журамд компанийн засаглалын кодекст тусгагдсан дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг үнэлэх зэрэг засаглалыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд багтаагүй байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд компанийн засаглалыг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлж үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан "Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам"-ыг мөрдлөг болгон үнэлж, түвшин тогтоох аргачлалыг боловсруулан ажиллах шаардлагатай байна.

1.1.3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд арга хэмжээ төлөвлөөгүй, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлээгүй байна

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт “Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх зарчим, ёс зүй, хэв шинжид тулгуурласан, аж ахуйн үйл ажиллагаа удирдан зохион байгуулах нийтлэг арга барил бүхий үндэсний компани, бизнес эрхлэгчдийг бий болгох” зорилгыг хэрэгжүүлэхээр 4 зорилт дэвшүүлж, 2011-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталжээ. Хөтөлбөрт тусгасан зорилтуудад үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2-т заасан зорилтын хүрээнд,
- Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4-т заасан зорилтын хүрээнд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт, үндсэн чиглэлийг Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулж 2016-2020 онд оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, төрийн байгууллагын манлайлал зэрэг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөөгүй байна. 2020-2024 онд төлөвлөсөн арга хэмжээнүүд дээрх үндэсний хөтөлбөрийн зорилттой уялдсан байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллана” гэсэн зорилтын хүрээнд болон 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт арга хэмжээ төлөвлөж, тусгаагүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт хангагдаагүй байна

1.2.1. Төрийн эрх бүхий байгууллагаас орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх тогтвортой бодлого баримталж ажиллаагүй байна

Компанийн засаглалын тухай ойлголт нь компанийн удирдлагын чадвар, зөв хяналт, хариуцлагатай байдлыг хамарсан харилцаа тул компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогод Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа гол байр суурийг эзэлдэг. Орон нутгийн өмчит компанийн хувьд засаглалыг сайжруулахад аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа чухал нөлөөтэй боловч энэ талаар төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5-д “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна” гэж заажээ.

“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг НААҮГ-ын даргын 1999 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар тус аймаг дахь НААҮ-ний байгууллагыг орон нутгийн өмчийн “Суат” ХХК болгон өөрчлөн компани хэлбэрээр зохион байгуулж, удирдах зөвлөл буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны ТУЗ нь хуралдаж 1999 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 01 дугаар тогтоолоор компанийн оноосон нэр, дүрмийг баталж, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагыг томилсон байна. “Суат” ХХК ОНӨААН-ийн дүрмийг анх баталснаас хойш өөрчлөлт оруулаагүй байна.

Компанийн дүрэмд анх батлагдсанаас хойш өөрчлөлт ороогүй, зарим заалт нь Компанийн тухай хуулийн заалттай нийцэхгүй байгаа зэрэг нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдон ажиллаж байсан бүрэлдэхүүн болон үе үеийн гүйцэтгэх удирдлагууд компанийн засаглалыг хөгжүүлэх талаар санаачилгагүй ажиллаж ирсэнтэй холбоотой байна.

Компанийн засаглалд ТУЗ-ийн үүрэг хариуцлага хамгийн гол байр суурийг эзэлдэг бөгөөд байнгын тогтвортой үйл ажиллагаатай, мэргэшсэн хараат бус гишүүдтэй байснаар компанийн сайн засаглалын бодлогыг хэрэгжүүлдэг.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 121 тоот тогтоолоор “Суат” ХХК-ны ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2022 он хүртэл ажиллуулсан байна.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д зааснаар ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх ёстой боловч энэ шаардлагыг хангаагүй хүмүүсийг томилон ажиллуулж ирсэн байна.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар хангаж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, компанийн үйл ажиллагааны гол шийдвэрүүдийг хараат бус гаргаж байх ёстой. Эдгээр шаардлага хангаагүй ТУЗ-ийн үед компанийн засаглал хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна гэж үздэг.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үр ашигтай ажиллуулах талаар хяналт тавьж орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага ба ОНӨГ-ын даргыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгээр томилж ажиллуулж байсан нь тухайн үед ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газар:

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрыг төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд шилжүүлэн, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болсон байна.

Дэд бүтцийн сайдын 1999 оны шийдвэрээр “Эрчим” ХК-ны бүтцийг өөрчилж, цахилгаан түгээх, хангах үүрэг бүхий Цахилгаан шугам сүлжээний газрыг байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан. Хуулийн 19 дүгээр зүйлд 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, 19.1.2-т гэрээнд “эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин” гэж заасан байна.

ЦШСГ-ын захиргаа, ажиллагсдыг төлөөлж үйлдвэрчний эвлэлийн хооронд 2018 онд хамтын гэрээг байгуулж, гэрээнд ажил эрхлэлт, ажлын байрын баталгаа, цалин хөлс, ажил амралтын цаг, ажиллагсдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, нийгэм ахуйн хөнгөлөлт, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл болзол, хамтын гэрээний биелэлтэд тавих хяналт зэргийг тусган мөрдөж ажиллаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.8, 19.9 дэх заалтуудад нийцсэн байна.

Тус газар нь эдийн засгийн хүрэх түвшнийг 1 жилээр боловсруулан гаргаж, ажлаа Удирдах зөвлөлд тайлагнаж, дүгнүүлж ирсэн байна.

Компанийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “... төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно” гэж заасан байна.

Тус орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийг аймгийн ИТХ-аас томилон ажиллуулж ирсэн бөгөөд Удирдах зөвлөлийн даргаар аймгийн ИТХ-ын дарга сонгогдон, 2016-2020 онд 3, 2020-2024 онд 5 гишүүнтэй ажилласан байна.

Удирдах зөвлөл нь байгууллагын жилийн төлөвлөгөөний биелэлтийг баталж, дүгнэн, төлөвлөгөөний биелэлтийг “хангалттай” гэж дүгнэж, дүгнэлтийг үндэслэн ажилчдын жилийн шагналын хэмжээг тогтоосон байна.

2016-2021 онд Удирдах зөвлөлийн хийсэн ажилтай танилцаж үзэхэд компанийн засаглалыг хөгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх үр нөлөө бүхий шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ”, 21.10-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аудитын дүгнэлт гарснаас хойш долоо хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заажээ.

ЦШСГ-ын удирдлага хуулийн дээрх заалтын дагуу үйлдвэрийн газрын хүрэх зорилт, хэрэгжүүлэх саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд хянуулж, батлуулж ирсэн боловч аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлээгүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байгууллагын хувьд орон нутгийн өмчийн талаар баримтлах аймгийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр чиглэлийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнаж ажиллаагүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь тус газрын үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаж байгаа боловч бусад үйл ажиллагаанд оролцохгүй ямар нэгэн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс үзэхэд төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс компанийн засаглалыг хөгжүүлэх талаар ямар нэгэн бодлого шийдвэр төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилт хангагдаагүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах заалтууд тусгагджээ. Үүнд:

2.93-т нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх;

2.95-д хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлэх;

2.96-д цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх;

5.2-т Эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр: 5.2.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана" гэж заажээ.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.93, 2.95, 2.96-д тусгасан зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт арга хэмжээ төлөвлөгдөөгүй, энэ нь төрөөс нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.5-д "Суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд Өлгий сумын багуудын цэвэр усны магистрал шугамын ажлыг гүйцэтгэх, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах, хэрэглэгчдийг тоолууржуулах ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2-т "Эрчим хүч, цахилгаан" хөтөлбөрийн хүрээнд 7 төрлийн ажлыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Дээрх зорилтын хүрээнд 2016-2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр газар авсан айл өрхийг цахилгааны шугамд холбох, ухаалаг тоолуурт холбох, сумдын цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах зорилгоор бетонон тулгууртай СИП кабель татах, гудамжны гэрэлтүүлгийг шийдвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.Үүнд:

Өлгий сумын төвийн 13 багийн хэрэглэгчийн тоо 2020 онд 18289-т хүрч, хэрэглэж байсан агаарын 0.4 кВ-ын шугамыг бетон тулгууртай, СИП кабелаар сольж ухаалаг тоолуур тавьснаар аймгийн төвийн цахилгаан алдагдал аймгийн дунджаар 2019 онд 17.4 хувь, 2020 онд 16.7 хувь, 2021 онд 16.3 хувь болж, алдагдлын түвшин 2020 онд урьд оноос 0.7 хувиар, 2020 онд 0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх ажлын дүнгээр компанийн ашигт ажиллагааг дэмжих, алдагдлыг бууруулах чиглэлээр алхам алхмаар тодорхой ажлууд хийгдэж ирсэн боловч компанийн засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын биелэлт хангагдаагүй байна.

1.2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт хүргэх нөхцөл бүрдээгүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нэг."Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын 1.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна", 4.4.10-т "4.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн

этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно”,

3.7.11-т хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

4.4.10-т төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгох;

6.2.7-д аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистрал шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ гэж тусгажээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7, 3.7.11, 6.2, 6.2.7-д дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих асуудлыг судлан шийдвэрлүүлэх;
- Өлгий суманд оршин сууж буй иргэдийн цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;
- Аймгийн төвийн цэвэр усны шугамтай багуудад цэвэр усны шугамыг ашиглаж ухаалаг ус түгээх цэгтэй болгох асуудлыг шийдвэрлэх;
- Цэвэр усны өргөх станцад шинээр гүний худаг гаргах хайгуул хийлгэх;
- Зарим багуудад хөлдөлтөөс хамгаалсан цэвэр усны шугам татан хэрэглэгчдийг холбож, туршилт хийх, хэрэглэгчдийг хөнгөлөлттэй үнээр тоолууржуулах;
- Өлгий сумын багуудад цэвэр усны шугам шинээр татаж, иргэдийн цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;
- Ундны усыг халдваргүйжүүлэх төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор хоолны давснаас хлор гарган авах иж бүрэн төхөөрөмжтэй болгох

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Өлгий сумын 2 дугаар багт 80.0 сая төгрөгөөр, 8 дугаар багт 69.0 сая төгрөгөөр цэвэр усны шугам татах ажил хийгдэж ашиглалтад оржээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5-д гэрэл, илч гэгээн амьдрал гэсэн хэсэгт 9 төрлийн ажлуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээрх зорилтын хүрээнд 2020-2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ЦШСГазрын өөрийн хөрөнгөөр аймгийн төвийн 3, 6, 9, 10,12,13 дугаар баг, Толбо, Бугат, Цэнгэл сумдын төвийг цахилгааны дамжуулах агаарын шугамыг СИП кабельтай болгож, 0.4 кв -ын цахилгааны дамжуулах агаарын шугамыг бүрэн шинэчилж, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлсэн байдалтай байна.

ЦШСГазрын өмчийн бүртгэл ашиглалтыг сайжруулах зорилтын хүрээнд өөрийн хөрөнгөөр 2021 онд “Бодит хүчин чадал” ХХК-наас трансформатор болон шугамын алдагдлын горим тооцоо хийх реле программын лицензийг 49.9 сая төгрөгөөр худалдаж авсан байна.

Үүний үр дүнд хэрэглэгч бүрийн кодоор цахилгааны төлбөр, Засгийн газраас үзүүлж буй хөнгөлөлт, зөрүү төлбөрийн мэдээг сар бүр мессежээр хүргэх, хэрэглэгчийн кодоор төлсөн төлбөрийг авлага данснаас хасах, цахилгаан дамжуулалтын алдагдлыг тооцож гаргах давуу талтай болсон байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10-т тусгасан зорилтын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх талаар арга хэмжээ төлөвлөж тусгаагүй байна.

1.2.4. Орон нутгийн хуулийн этгээдийн эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага болон ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөөгүй байна

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6-д “орон нутгийн өмчит компанийн өмчлөгч нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна” гэж хуульчилжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1-д заасны дагуу аймгийн Засаг дарга нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй бөгөөд аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн талаар хэрэгжүүлэх бодлогын хүрээнд:

- орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үр ашигтай ажиллуулахад хяналт тавьж орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх,

- орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид бүртгэлээр хяналт тавих, зөрчлийг арилгуулах талаар эрхэм зорилго, зорилтыг дэвшүүлсэн байна.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд Орон нутгийн өмчийн газраас төлөвлөж, хэрэгжүүлсэн ажил байхгүй, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно” гэж заасан.

- Суат” ХХК-ны 1999 онд баталсан компанийн дүрэмд “Компанийн ТУЗ улиралд 1 удаа ээлжит болон ээлжит бусаар хуралдана. Хурлыг жилд 2-оос доошгүй удаа, компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор хийнэ” гэж заасан боловч ТУЗ-ийн 2019-2021 оны хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримт материалыг

ирүүлээгүй, хөтөлсөн хурлын тэмдэглэл байхгүй, зөвхөн цалин, урамшуулал, гүйцэтгэх захирлын цалинг баталсан тогтоолыг ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газраас тус компанийн үйл ажиллагаанд 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар ТУЗ нь эрх, үүргээ хангалтгүй хэрэгжүүлж компанийн 2015, 2016, 2017 оны үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг батлаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах зөвлөмж, албан шаардлага өгөгдөж байсан боловч зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д “Компани нь дараах баримт бичгийг хадгалах үүрэгтэй”, 97.1.2-т “хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг” 97.1.10-т “төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, шийдвэр, тушаал”, 97.2-т “Компани нь дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй”, 97.2.2-т “төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, шийдвэр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй Орон нутгийн өмчийн газар болон “Суат” ХХК-ны ТУЗ нь хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй, үйл ажиллагаа нь үр нөлөөгүй байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах бодлогын хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхаарч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх бодлогыг сайжруулахад эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Орон нутгийн өмчийн газарт орон нутгийн өмчит хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үр ашигтай ажиллуулахад хяналт тавьж орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

“Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлд ТУЗ-ийн үйл ажиллагааны журам баталж, үйл ажиллагаагаа сайжруулах, бодлого, шийдвэрийн үр нөлөөг дээшлүүлэх, хурлын тэмдэглэлийг хуульд заасны дагуу хөтлөх, гаргасан шийдвэр, бусад холбогдох ажлын баримтуудыг компанид хадгалуулах, ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн даргыг нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамруулах талаар албан шаардлага өгөв.

“Суат” ХХК-д Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1, 97.1.2, 97.1.10, 97.2, 97.2.2-т заасныг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага, “компанийн дүрмийг Компанийн тухай хууль, Орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэх талаар зөвлөмж хүргүүлэв.

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дугаар сарын 29-ны өдрийн 135 тоот тогтоолоор ЦШСГ-ын Удирдах зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Удирдах зөвлөлийн даргаар аймгийн ИТХ-ын даргыг, гишүүдээр аймгийн ИТХ-ын

тэргүүлэгч 1, аймгийн ИТХ-ын төлөөлөгч 2, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ын даргыг томилсон байна.

Удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 05-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2019 оны, 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2021 оны, 2021 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2022 оны Цахилгаан шугам сүлжээний газрын бизнес санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

Удирдах зөвлөлийн хурлаар Цахилгаан шугам сүлжээний газрын 2019, 2020, 2021 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэжээ.

Удирдах зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолоор ЦШСГ-ын дотоод хяналт, шинжилгээний ажилтныг томилж, 10 сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоолоор дотоод хяналт шалгалтын журмыг баталсан байна.

Удирдах зөвлөл нь 2016-2021 онд ЦШСГ-ын үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, ерөнхий нягтлан бодогчийг томилох шийдвэр гаргаж, ЦШСГ-ын үйл ажиллагааг дүгнэсэн, бизнес төлөвлөгөөг баталж, жилийн үр дүнгийн шагналыг хэмжээг тогтоосон шийдвэрүүдийг гаргаж ажилласан байна.

Удирдах зөвлөлөөс ЦШСГ-ын жил бүрийн бизнес, санхүүгийн төлөвлөгөөг баталсан тогтоол гаргасан боловч тогтоолын хавсралтаар бизнес, санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй байгаа нь төлөвлөгөө, гүйцэтгэл бодитой гарахгүй байх эрсдэлийг бий болгосон байна.

Удирдах зөвлөл нь компанийн бизнесийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааг дүгнэж ирсэн боловч орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулж, ашигт ажиллагааг дэмжсэн шийдвэр гаргаагүй, үйл ажиллагааг бодитой үнэлж дүгнээгүй байна.

Аудитын дүнгээр Удирдах зөвлөлөөс цаашид тус газрын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр тогтоолын хавсралтаар баталж ажиллахыг зөвлөмж болголоо.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага нь хянаж батлаагүй байна

2.1.1. “Суат” ХХК-ны эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж, батлуулаагүй байна

“Суат” ХХК нь НААҮГ-т санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээр гүйцэтгэлийг гаргаж, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны санхүү, эдийн засгийн тайланг жил бүр хүргүүлж байсан боловч эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж, ТУЗ-өөр батлуулан ажиллаагүй байна.

ЦШСГ нь эдийн засгийн үр ашгийн тооцоо, бизнес, санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүр гаргаж, Удирдах зөвлөл болон Эрчим хүчний зохицуулах хороонд тайлагнаж ирсэн байна.

Цахилгааны худалдан авалт, түгээлттэй холбоотой төлөвлөлт нь дараах байдалтай байна.Үүнд:

“ББЭХ-ний систем” ТӨХК-аас худалдан авах цахилгааны хэмжээ, борлуулах цахилгааны хэмжээг төлөвлөхдөө урьд онуудын худалдаж авсан, борлуулсан кв/цаг цахилгааны хэмжээ, тайлант онд нэмэгдсэн хэрэглэгчдийн тоог үндэслэж, төлөвлөгөөг “ББЭХ-ний систем” ТӨХК-аар хянуулж, саналыг нь авч ажилласан байна.

“ББЭХ-ний систем” ТӨХК-аас 2019-2021 онд худалдан авах цахилгааны хэмжээ, нийлүүлэх байгууллага, цахилгаан түгээлтийн байдлыг дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт № 01

/мян.квт цаг/

Үзүүлэлт	2019			2020			2021		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлтийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлтийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлтийн хувь
Түгээлтэнд авсан цахилгаан	50938.0	52024.5	102.1	53183.0	53076.40	99.80	61888.0	64407.25	104.07
түгээлтэнд авсан цахилгааны дундаж тариф	100.17	100.17	100.0	193.2	175.3	90.74	168.11	163.91	97.50
Түгээлтэнд авсан	5,102.5	5,211.3	102.1	10,275.0	9,304.7	90.56	10,403.9	10,556.8	101.47
Цахилгаан Биет	8,850.0	9,046.0	102.2	9,900.0	8,848.0	89.37	10,200.0	10,511.7	103.06
түгээлтийн Хувь	17.4	17.4	100.1	18.6	16.7	89.55	16.5	16.3	99.02
Үүнээс: техникийн Биетээр	5,093.8	5,202.0	102.1	5,318.0	5,308.0	99.81	6,188.8	6,440.70	104.07
Хувиар	10.0	10.0	100.0	10.0	10.0	100.01	10.0	10.0	100.00
Биетээр	3,756.2	3,844.0	102.3	4582.0	3540.0	77.26	4,011.2	4,071.00	101.49
Хувиар	7.4	7.4	100.2	8.6	6.7	77.41	6.5	6.3	97.52
Борлуулсан цахилгаан	42,088.0	42,978.5	102.1	43,283.0	44,228.40	102.18	51,688.0	53,895.6	104.27
Борлуулсан цахилгааны дундаж тариф	181.16	171.67	94.8	235.88	208.77	88.50	199.98	194.63	97.33

Эх сурвалж: ЦШСГ-ын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

2019 онд 50.9 сая квт/цаг, 2020 онд 54.9 сая квт/цаг, 61.9 сая квт/цаг цахилгаан худалдаж авахаар төлөвлөжээ. Үүнээс: 2019 онд тооцох 8.8 сая квт/цаг, 2020 оны 9.4 сая квт/цаг, 2021 оны 10.2 сая квт/цаг алдагдлыг хасаж тооцоход 2019 онд 42.1 сая квт/цагийн, 2020 онд 45.5 сая квт/цагийн, 2020 онд 51.7 сая квт/цагийн цахилгааны борлуулахаар төлөвлөжээ.

Худалдан борлуулах цахилгааныг аймаг сумдын хэрэглэгчдээр нь ангилж үзэхэд 26.1 хувийг хөдөө сумд, 70.4 хувийг Өлгий сумд, 3.5 хувийг уурхай авахаар төлөвлөсөн байна.

Борлуулах цахилгааны хэмжээг 2020 онд 2019 оноос 3.9 сая квт/цагаар, 2021 онд 6.9 сая квт/цагаар нэмэгдүүлэхээр төлөвлөж, алдагдлын түвшнийг 2019 онд 17.37 хувь байхаар төлөвлөж, 2020 онд 17.05 хувь болгож, 0.32 хувиар бууруулахаар, 2021 онд 16.5 хувь болгож, 0.55 хувиар бууруулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2019 онд 52.0 сая квт/цаг цахилгаан борлуулж, төлөвлөгөөг 102.1 хувиар, 2021 онд 64.4 сая квт/цаг цахилгаан борлуулж, төлөвлөгөөг 104.7 хувиар давуулан биелүүлж, 2020 онд 53,1 сая квт/цаг цахилгаан борлуулж, төлөвлөгөө 0.2 хувиар тасалсан байна.

Цахилгааны алдагдлыг 2019 онд 17.4 хувийн алдагдалтай ажиллаж, төлөвлөсөн хэмжээнээс хэтрээгүй бол 2020 онд 16.7 хувийн алдагдалтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлын түвшнийг 1.9 хувиар, 2021 онд 16.3 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, алдагдлын түвшнийг 0.2 хувиар бууруулж ажилласан байна.

Үйл ажиллагааны орлого, зардалтай холбоотой төлөвлөлт дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт №02

Үзүүлэлт	2019			2020			2021		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	биелэлтийн хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	биелэлтийн хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	биелэлтийн хувь
Борлуулалтын орлого	7,454.40	8,558.70	114.81	10,576.30	9,233.40	87.30	7,904.90	10,489.80	132.70
Үйл ажиллагааны бус орлого	133.20	71.20	53.45	65.20	71.30	109.36	76.70	67.00	87.35
Түгээх үйлчилгээний төлбөр	-	-	-	-	-	#DIV/0!	2,431.50	-	-
Орлогын дүн	7,587.60	8,629.90	113.74	10,641.50	9,304.70	87.44	10,413.10	10,556.80	101.38
Үйл ажиллагааны зардал	2,880.10	2,820.90	97.94	3,471.80	3,011.90	86.75	3,540.50	3,329.10	94.03
Үйл ажиллагааны бус зардал	4,919.70	6,167.10	125.36	7,195.80	6,621.40	92.02	7,129.90	7,444.20	104.41
Зардлын дүн	7,799.80	8,988.00	115.23	10,667.60	9,633.30	90.30	10,670.40	10,773.30	100.96
ашиг, алдагдал	(212.20)	(358.10)		(26.10)	(328.60)		(257.30)	(216.50)	

Эх сурвалж: ЦШСГ-ын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг нийт борлуулалтын орлого, нийт зардал, нийт авлага, өглөг, эргэлттийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө, нийт ажиллагсад, цалингийн сан, дундаж цалин, түгээлтэд авсан цахилгаан, түгээх цахилгааны нийт өртөг, цахилгааны алдагдлын түвшин зэрэг үзүүлэлтүүдээр задруулан төлөвлөгөө гүйцэтгэлийг гаргаж, тайлагнаж ирсэн байна.

Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 2019 онд 13.7 хувиар, 2021 онд 4.4 хувиар давуулан биелүүлж, 2020 онд 12.6 хувиар тасалдуулсан байна.

Нийт зардлын төлөвлөгөөг 2019 онд 15.2 хувиар, 2021 онд г 0.9 сая төгрөгөөр хэтрүүлж, 2020 онд 9.7 хувиар хэмнэсэн байна. Үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой 2019 онд борлуулсан бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэн нь нийт зардлын хэмжээ өсөхөд нөлөөлсөн байна.

Тус газрын алдагдлын хэмжээ 2019-2021 онд төлөвлөснөөс 40.8-302.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.1.2. Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага хянаж батлах асуудал дутагдалтай байна

Компанийн дүрмийн 5.5-д “Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байна”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн талаар 6 дугаар зүйлийн 6.1.2-т “Компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, цалингийн сан, урамшууллын хэлбэрийг батлах” гэж тусгажээ.

Компанийн дүрэмд заасны дагуу компанийн эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлагын төлөвлөгөөг боловсруулж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хэлэлцүүлж батлаад, эрх бүхий байгууллагад хүргүүлж хянуулж ажиллах ёстой.

“Суат” ХХК-ийн эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлагын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөл хянаж батлаагүй, Орон нутгийн өмчийн газар эдийн засгийн зорилтот түвшнийг хянаж ажиллаагүй байна.

“Суат” ХХК-д компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, эрх бүхий байгууллагаар хянуулж, батлуулж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

ЦШСГ нь үйл ажиллагааны эдийн засгийн зорилтот түвшнийг жил бүр төлөвлөж, үйл ажиллагааны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг гаргаж, Удирдах зөвлөлийн тогтоолоор батлуулсан байна.

ББЭХС ТӨХК-аас худалдан авах цахилгааны кв/цаг, худалдах кв/цагийг урьд онуудын гүйцэтгэл, цахилгаан хэрэглэгчийн тоог үндэслэн гаргаж, эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын биелэлтийг дүгнэж, шинэчлэн тогтоох тухай тогтоол гаргуулан ажиллаж ирсэн байна.

Тухайлбал: Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн ЦШСГ ОНӨААТҮГ-ын цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2020 оны зорилтын биелэлтийг гаргаж, 2021 оны мөрдөж ажиллах зорилтыг баталсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос жил бүрийн цахилгаан дамжуулалт түгээлтийн алдагдлын түвшнийг баталсныг бизнес төлөвлөгөө боловсруулахдаа үндэслэл болгосон байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 352 дугаар тогтоолоор орон нутгийн дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг Баян-Өлгий аймагт 17.4 хувиар, 2019 оны 485 дугаар тогтоолоор 2020 онд мөрдөх цахилгаан түгээлтийн алдагдлыг 17.05 хувиар, 2020 оны 541 дүгээр тогтоолоор 2021 онд мөрдөх цахилгаан түгээлтийн алдагдлыг 16.5 хувиар тус тус тогтоосон байна.

Тус газрын Удирдах зөвлөлөөр 2019-2021 онуудын үйл ажиллагааны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг баталсан тогтоол гаргасан боловч төлөвлөгөөг тогтоолын хавсралтаар баталж албажуулаагүй байна. Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг эрх бүхий ОНӨГ нь ЦШСГ-ын үйл ажиллагааны зорилтот түвшин, үйл ажиллагааны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг хянаагүй байна.

ЦШСГ-ыг 2019 онд 212.2 сая төгрөгийн 2020 онд 26.1 сая төгрөгийн, 2021 онд 257.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Тус үйлдвэрийн газрын захиргаа аж ахуй, ашиглалтын, борлуулалтын, дизель станцын гэсэн 4 тасгаас зардлын саналыг авч, нэгтгэн төлөвлөгөөндөө тусгаж ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ”,

Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Аймаг, нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана” гэж заасны дагуу тус газар нь бизнес, санхүүгийн төлөвлөгөөг төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий байгууллага Орон нутгийн өмчийн газарт хүргүүлдэггүй, тус газраас ЦШСГ-ын үйл ажиллагааны зорилтот түвшин, үйл ажиллагааны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг хянаагүй байна.

Аудитын дүнгээр Орон нутгийн өмчийн газарт орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хэрэгжүүлэх зорилтот түвшнийг оновчтой төлөвлөсөн эсэхийг хянаж, батлах, хэрэгжилтийг хангуулах, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

2.2. “Суат” ХХК-ны орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, ЦШСГ орлогын бүрдүүлэлт зорилтот түвшнийг хангаж ажилласан байна

2.2.1. Суат” ХХК төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй, ЦШСГ худалдан борлуулсан цахилгаан эрчим хүчний орлогын дундаж барагдуулалт 98.8 хувьтай байна

Компанийн дүрэмд заасны дагуу компанийн гүйцэтгэх захирал үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг боловсруулж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр батлуулж ажиллах ёстой. Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т ТУЗ нь компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, цалингийн сан, урамшууллын хэлбэрийг батлахаар тусгасан байна.

“Суат” ХХК нь орлого, зарлагын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хянуулж батлуулаагүй, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Суат” ХХК нь 2019, 2020 онд 950.6 сая, 2021 онд 953.7 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж ажилласан байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг он оноор авч үзвэл 2019 онд 6.3 хувиар, 2020 онд 2.9 хувиар тасарч 2021 онд 30.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөлт үндсэн болон туслах үйл ажиллагааны төрлөөр:

Хүснэгт №03		сая төгрөгөөр					
Үйл ажиллагааны төрөл	Цех, тасаг	2019 он		2020 он		2021 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн үйл ажиллагаа	Цэвэр ус	665.8	325.0	665.8	364.7	756.2	894.4
	Бохир ус		355.1		361.1		
	Халуун ус	182.1	182.1	156.0	156.9		148.3
Туслах үйл ажиллагаа	Барилга угсралт	102.7	4.3	128.8	4.5	197.5	54.7
	Бусад		24.4		25.3		147.7
	Блокны үйлдвэр		-		10.8		
Дүн		950.6	890.9	950.6	923.3	953.7	1,245.1

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 2019 онд 14.3 сая, 2020 онд 60.0 сая, 2021 онд 286.5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2019 онд 74.0 сая, 2020 онд 88.2 сая төгрөгөөр тасарч 2021 онд 4.9 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс техникийн нөхцөл авалгүй цэвэр усны гол магистрал шугамд холбогдсон хэрэглэгч байгаа эсэх талаар хяналт хэрэгжүүлж ажилласнаар 2019-2021 онуудад хэрэглэгчийн тоо нэмэгдэж, орлого нэмэгдэх боломж бүрдсэн байна.

Тухайлбал: Жил бүр ажлын хэсэг гаргаж цэвэр усны магистрал шугамд холбогдсон худгийн тооллого, худгаас цэвэр усны шугамд холбогдсон айл өрх, байгууллагын тоог гаргаж, бүртгэлд оруулж, гэрээ байгуулсан эсэхийг шалгаж, зөрчлийг арилгуулж техникийн нөхцөлийн хураамжийн орлогыг төлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитаар 2018 оныг суурь он болгон авч 2019-2021 онд цэвэр усны шугамд холбогдсон айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн талаар судалгаа хийлээ.

Хүснэгт №04 Цэвэр усанд 2019-2021 онд холбогдсон хэрэглэгчдийн судалгаа

Айл өрх, ААНБ	2018	2019	Зөрүү /2-1/	2020	Зөрүү /4-2/	2021	Зөрүү /6-4/	Нийт нэмэгдсэн хэрэглэгч /3+5+7/
	1	2	3	4	5	6	7	8
Орон сууц	45	50	5	59	9	61	2	16
Гэр хороолол	581	669	88	724	55	757	33	176
ААНБ	187	201	14	218	17	227	9	40
Дүн	813	920	107	1001	81	1045	44	232

Эх сурвалж: Аудитын судалгаа

Шинээр цэвэр, бохир усны шугамд холбогдсон хэрэглэгчийн тоо 2018-2019 онд 107 байхад олгосон техникийн нөхцөл 28 бол 2019-2020 онд 81 хэрэглэгч шинээр нэмэгдэж 75 техникийн нөхцөл олгосон, 2020-2021 онд 44 хэрэглэгч нэмэгдэж 43 техникийн нөхцөл олгосон байна.

“Суат” ХХК-ны нийт хэрэглэгчийн тоо 2019-2021 онд 232-оор нэмэгдсэн байхад олгосон техникийн нөхцөл 146 ба 86 хэрэглэгчид техникийн нөхцөл олгогдоогүй буюу хураамж төлөөгүй, цэвэр усны шугамд холбогдсон байна.

“Суат” ХХК-ны албан байгууллага болон айл өрхүүдэд олгосон техникийн нөхцөл олголтын тарифыг зэргэлдээ Ховд, Увс аймгуудын үнэ тарифтай харьцуулж судалгааг хийж үзэхэд “Суат” ХХК-ны айл өрхүүдэд олгох техникийн нөхцөлийн үнэ 85.0 мянган төгрөг байгаа нь Увс аймгийн үнэ тарифаас 37.0 мянган төгрөгөөр илүү, Ховд аймгийн үнэ тарифаас 65.0 мянган төгрөгөөр бага байна.

Албан байгууллагад олгох техникийн нөхцөлийн үнэ 120.0 мянган төгрөг байгаа нь Увс аймгийн үнэ тарифаас 8.0 мянган төгрөгөөр, Ховд аймгийн үнэ тарифаас 210.0 мянган төгрөгөөр бага байна.

Техникийн нөхцөлийн үнэ тариф зэргэлдээ аймгуудаас 29.2-57.1 хувиар бага байгаа нь компанийн орлого нэмэгдүүлэх, алдагдал, өр төлбөрийг барагдуулах бодлого баримталж ажиллаагүй байгааг харуулж байна.

“Суат” ХХК нь техникийн нөхцөл олгоходоо бүрдүүлж байгаа бичиг баримт нь хангалтгүй байна. Тухайлбал: хураамжийн орлого дансанд ороогүй, техникийн нөхцөлийн хураамжийг төлсөн баримтыг хавсаргаагүй, кадастрын зураг, газрын гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг нотлох баримтуудыг бүрдүүлж аваагүй, бүртгэл, тооцоо нь хангалтгүй, техникийн нөхцөл олгож байгаа байдалд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн төвийн цэвэр усны магистрал шугамууд “Суат” ХХК-ны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Компани нь цэвэр усаар, ариутгах үйлчилгээг авч байгаа айл өрх, албан байгууллага, ААНБ-аас олсон орлогоор санхүүжиж байгаа, энэ үйл ажиллагааг явуулах чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллагын хувьд энэ чиглэлийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх ёстой байгууллага юм.

Мэргэжлийн байгууллагын хувьд “Суат” ХХК айл өрх, албан байгууллагыг олгосон техникийн нөхцөлийн дагуу холбож, хэрэглэгчээр бүртгэж авах ёстой боловч айл өрхийг цэвэр усны магистрал шугамд холбох ажлыг хийддэггүй, компанийн эрх бүхий байгууллага энэ талаар мэдээлэлгүй эсвэл анхаарал хандуулж ажиллаагүй байна. Компанийн гүйцэтгэх захирал компанийн слесарууд өдрийн цагаар засвар үйлчилгээ хийдгээс цэвэр усанд холбох ажлыг хийх ажилтан хүрэлцдэггүйгээс слесарууд хувиараа хийдэг гэсэн тайлбар өгчээ.

Компанийн дүрмийн 8 дугаар зүйлд эрх бүхий албан тушаалтнууд компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах үүрэг хариуцлагын талаар тусгасан. Удирдлагаас ажилтнуудад компанийн үйл ажиллагаатай хамааралтай ажлыг хувиараа гүйцэтгэж, хувьдаа орлого олох боломж олгосон байна.

Энэ нь орон нутгийн өмчит компанийн орлогыг нэмэгдүүлэх, компанийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх талаар бодлого алдагдсан, гүйцэтгэх удирдлага, ерөнхий инженер болон дээрх ажлыг гүйцэтгэж хувьдаа орлого олж байгаа ажилтнуудын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн асуудал гэж үзэх үндэслэлтэй байна.

Аудитын дүнгээр “Суат” ХХК-д цэвэр, бохир усны шугамд айл өрх, албан байгууллагыг холбох ажлыг мэргэжлийн байгууллагын хувьд чиг үүргийнхээ дагуу гүйцэтгэж, зөрчлийг арилгах, техникийн нөхцөл авалгүй дур мэдэн холболт хийсэн байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа зөрчлийг арилгаж, техникийн нөхцөл нөхөж олгох, техникийн нөхцөлийн хураамжийн орлогыг компанийн дансанд оруулах, техникийн нөхцөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн бүрдүүлэлтийг хангах, техникийн нөхцөл олгох үнэ тарифыг нь шинэчлэх талаар албан шаардлага өгөв.

ЦШСГ-ын борлуулалтын алба нь цахилгааны хэрэглээний заалт авах, авлага барагдуулах, тоолуур техник үйлчилгээний хэсэг гэсэн 3 хэсэгт хуваагдаж, дараах байдлаар үйл ажиллагаа явуулж иржээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 103 дугаар тогтоолоор уул уурхай олборлох, боловсруулах аж үйлдвэрт 1 кв/цагийн цахилгааны тарифыг 151.6 төгрөгөөр, бусад үйлдвэр аж ахуйн нэгжид 148.2 төгрөгөөр, айл өрхөд 110.8 төгрөгөөр, айл өрхийн суурь хураамжийг 2000 төгрөг байхаар тогтоосныг мөрдөж ажилласан байна.

Мөн Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 410 дугаар тогтоолоор “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-иас худалдан авах цахилгааны тарифыг 153.1 төгрөгөөр, “ББЭХС” ТӨХК-д төлөх түгээх үйлчилгээний тарифыг 273.7 сая төгрөг байхаар тогтоосныг мөрдөж ажиллажээ.

Хүснэгт №05				/сая төгрөгөөр/						
№	Үзүүлэлт		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	2019		2020		2021	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд										
1	Нийт орлого		1	сая.төг	7,587.6	8,629.9	10,641.5	9,304.7	10,413.1	10,556.8
	Үүнээс: Борлуулалт	Бичилт	2	сая.төг	7454.4	8558.7	10576.3	9233.4	10,336.4	10,489.8
		Цуглуулалт	3	сая.төг	6961.2	8986.2	8254.3	9585	9,121.6	9,211.5
	Борлуулалтын орлого цуглуулалтын хувь		4	%	93.4	105.0	78.0	103.8	88.2	87.8
	Үйл ажиллагааны бус орлого		5	сая.төг	133.2	71.2	65.2	71.3	76.7	67.0

Эх сурвалж: ЦШС-ний газрын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолын дагуу 2020 онд 3563 хэрэглэгчдэд 207.9 сая төгрөгийн хөнгөлөлтийг, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу 2021 онд 17488 айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хэрэглэсэн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцаж, нийт 5692.0 сая төгрөгийн төгрөгийн хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн байна.

ЦШСГ-ын борлуулалтын орлогын барагдуулалт 2019 онд 105 хувиар, 2020 онд 103.8 хувиар, 2021 онд 87.8 хувиар биелэгдсэн байна.

2.2.2. “Суат” ХХК төсөвт төвлөрүүлэх татварыг хугацаанд төвлөрүүлээгүйгээс 234.5 сая төгрөгийн он дамжсан өр үүсгэсэн байна

“Суат” ХХК-ны 2018 оны санхүүгийн тайлангаар НӨАТ-ын 152.5 сая төгрөгийн өглөгтэй байсан ба 2019 онд төсөвт 101.1 сая төгрөгийн НӨАТ-ыг төвлөрүүлж, өмнөх оны өглөгөөс 20.8 сая төгрөгийг барагдуулж, оны эцэст 131.7 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Хүснэгт №06	Татварын өр төлбөрийн судалгаа		сая төгрөгөөр
2018 он	2019 он	2020 он	2021 он
152.6	131.7	236.2	234.5

Эх сурвалж: “Суат” ХХК-ны 2019-2021 онуудын санхүүгийн тайлан

2020 онд төсөвт 104.5 сая төгрөгийн НӨАТ-ыг төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тайлагнасан байна. Төсөвт төвлөрүүлэх татварыг 2021 онд бүрэн төвлөрүүлсэн боловч өмнөх онуудад үүссэн өглөгөөс 2.0 сая төгрөгийг барагдуулж жилийн эцэст НӨАТ-т 234.5 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгаас 2019 онд “Суат” ХХК-ны 2014-2017 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж 20.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Тухайлбал: Бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч төсөвт төлөөгүй 6.1 сая, НӨАТ-ын борлуулалтын орлогыг жилийн дүнгээр тооцоо хийлгүй, дутуу тооцсон 7.3 сая төгрөгийн зөрчилд 4.0 сая төгрөгийн торгууль, 2.7 сая төгрөгийн алданги тооцжээ.

Татварыг хугацаанд төлөөгүйд хуульд заасны дагуу алданги тооцсон эсэхийг судалж үзэхэд 2018 оноос хойш татварын өглөгтэй байсан боловч татварын өглөгт алданги тооцож байгаагүй ба аймгийн Татварын хэлтсээс “Суат” ХХК-д НӨАТ-ын өглөгийг барагдуулах шаардлага тавьж, дансыг нь хаах арга хэмжээ авч байжээ.

Татварыг хуулийн хугацаанд төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана”, 16.1.1-д “тухайн сард борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг албан татвар суутган төлөгч төсөвт төлнө гэсэн” заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Татварын хэлтэс Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан дараах зарчмыг үндэслэн тогтооно”, 73.2-т “Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно”, 73.2.1-д “татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор” гэснийг хэрэгжүүлээгүй, алданги тооцоогүй байна.

Аудитаар 2018-2021 онд төсөвт төвлөрүүлээгүй НӨАТ-т алданги ногдуулж тооцоог гаргахад:

- 2018 онд 140.0 сая төгрөгийн татварт 150 хоногт 0.050 хувиар бодож алданги тооцоход 10.5 сая төгрөг
- 2019 онд 106.1 сая төгрөгийн татварт 210 хоногт 0.046 хувиар бодож алданги тооцоход 10.2 сая төгрөг
- 2020 онд 35.8 сая төгрөгийн татварт 360 хоногт 0.045 хувиар бодож алданги тооцоход 5.8 сая төгрөг
- 2021 онд 134.3 сая төгрөгийн татварт 360 хоногт 0.044 хувиар бодож алданги тооцоход 21.3 сая төгрөгийн, нийтдээ 47.8 сая төгрөгийн алдангийн тооцоо гарч байна.

Аудитын дүнгээр “Суат” ХХК-д төсөвт төвлөрүүлээгүй олон жил болсон татварын өр төлбөрийг барагдуулах талаар албан шаардлага өгч, НӨАТ-ын өглөгийг хуулийн хугацаанд төлөөгүй зөрчилд 47.8 сая төгрөгийн алданги тооцож төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

ЦШСГ нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжуудын ногдуулалт, төлөлтийн тооцоог цаг тухайд нь хийж төвлөрүүлж ажилласан байна.

НӨАТ-т 2019-2021 онд нийтдээ 2820.1 сая төгрөгийн ногдуулалт хийж, 2039.2 сая төгрөгийн хасалт хийж, 884.6 сая төгрөгийг улсын төсөвт төлж, 2021 оны эцэст 171.4 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

ААНОАТ-т 2019-2021 онд нийтдээ 75.3 сая төгрөгийн ногдуулалт хийж, 76.3 сая төгрөгийг төсөвт төлж, өглөгийг бүрэн барагдуулсан байна.

ХХОАТ-т 2019-2021 онд нийтдээ 339.7 сая төгрөгийн ногдуулалт хийж, 341.2 сая төгрөгийг төсөвт төлж, 2021 оны эцэст 1.5 сая төгрөгийн авлагатай гарчээ.

ҮХХАТ-т 2019-2021 онд 16.0 сая төгрөгийн ногдуулалт хийж, 21.0 сая төгрөгийг төсөвт төлж, 2021 оны эцэст 8.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд ЦШСГ нь улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөр хураамжийг хугацаанд барагдуулж ажилласан байна.

2.3. “Суат” ХХК-ны үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаагүй, үр ашиггүй байна

2.3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүй байна

Санхүүгийн тайланд шинжилгээ хийснээр компани өнгөрсөн болон өнөөгийн үйл ажиллагааны түвшин, төлбөрийн чадвар, хөрөнгө ашиглалтын байдал, өрийн түвшин ямар байна, ашигтай ажиллаж боломж байгаа эсэхийг мэдэж цаашид оновчтой шийдвэр гаргах, төсвөө үндэслэлтэй төлөвлөх ач холбогдолтой боловч “Суат” ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа эдийн засгийн дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аудитаар компанийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийлээ.

Үйл ажиллагааны шинжилгээ

12-р сарын 31, 2019-2021 он

Хүснэгт №07

сая төгрөгөөр

	Сая төгрөгөөр			Эзлэх хувийн жин			Өсөлтийн хувь	
	2019	2020	2021	2019	2020	2021	2019-2020	2020-2021
Хөрөнгө								
Бэлэн мөнгө	3.2	9.4	0.8	4.2%	0.1%	0.0%	192.8	-91.8
Дансны авлага	141.0	151.8	221.4	1.8%	1.8%	2.7%	7.7	45.9
Бараа материал	51.9	39.2	51.0	0.7%	0.5%	0.6%	-24.6	30.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	13.4	13.4	12.3	0.2%	0.2%	0.2%	0.0	-8.1
Нийт эргэлтийн хөрөнгө	209.5	213.7	285.5	2.7%	2.6%	3.5%	2.0	33.6
Үндсэн хөрөнгө	7,751.4	8,500.7	8,103.3	100.9%	103.3%	99.5%	9.7	-4.7
Биет бус хөрөнгө	1,056.9	1,056.9	1,064.7	13.8%	12.8%	13.1%	0.0	0.7
Нийт үндсэн хөрөнгө	8,808.4	9,557.6	9,168.0	114.7%	116.1%	112.5%	8.5	-4.1
Хасагдах: хуимтлагдсан элэгдэл	(1,338.4)	(1,540.9)	(1,307.5)	-17.4%	-18.7%	-16.1%	15.1	-15.1
Цэвэр үндсэн хөрөнгө	7,470.0	8,016.7	7,860.5	97.3%	97.4%	96.5%	7.3	-1.9
Нийт Хөрөнгө	7,679.5	8,230.5	8,146.0	100.0%	100.0%	100.0%	7.2	-1.0
Өр төлбөр ба ХНХ								
Цалингийн өр	25.8	21.6	13.1	0.3%	0.3%	0.2%	-16.1	-39.3
Дансны өр	57.1	79.5	36.2	0.7%	1.0%	0.4%	39.2	-54.5
Татварын өр	131.8	236.2	234.5	1.7%	2.9%	2.9%	79.2	-0.7
Нийт эргэлтийн эх үүсвэр	214.6	337.3	283.8	2.8%	4.1%	3.5%	57.1	-15.9
Урт хугацаат өр	991.1	991.1	991.1	12.9%	12.0%	12.2%	0.0	0.0
Бусад урт хугацаат өр	-	-	-					
Нийт урт хугацаат өр	991.1	991.1	991.1	12.9%	12.0%	12.2%	0.0	0.0
Нийт Пассив	1,205.7	1,328.3	1,274.9	15.7%	16.1%	15.7%	10.2	-4.0
Төрийн өмч	2,652.4	3,295.2	3,295.2	34.5%	40.0%	40.5%	24.2	0.0
Дахин үнэлгээний нөөц	4,505.8	4,505.8	4,505.8	58.7%	54.7%	55.3%	0.0	0.0
Хуримтлагдсан ашиг алдагдал	(684.4)	(898.8)	(929.8)	-8.9%	-10.9%	-11.4%	31.3	3.4
Хувь нийлүүлсэн хөрөнгө	6,473.76	6,902.15	6,871.18	84.3%	83.9%	84.3%	6.6	-0.4
Нийт пассив болон хувь нийлүүлсэн хөрөнгө	7,679.46	8,230.5	8,146.0	100.0%	100.0%	100.0%	7.2	-1.0

Эх сурвалж: Суат ХХК-д хийсэн аудитын шинжилгээ

Нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн дүн 2019-2020 онд 7.2 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлтөд дансны авлага 7.7 хувь, үндсэн хөрөнгө 9.7 хувиар өссөн нь нөлөөлжээ. Байгууллагуудаас авах авлага нэмэгдэж, конторын шинэ байрыг орлогод авсантай холбоотой үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн өсөлтөд дансны өр 39.2 хувиар, татварын өр 79.2 хувиар, орон нутгийн өмчийн дүн 24.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Хуримтлагдсан алдагдал 31.3 хувиар өссөн байна.

Нийт хөрөнгө, өр төлбөр болон цэвэр хөрөнгө, өмчийн дүн 2020-2021 онд 1 хувиар буурч авлагын үлдэгдэл 45.9 хувиар, бараа материалын үлдэгдэл 30.2 хувиар өссөн байна.

Өр төлбөр болон цэвэр хөрөнгө, өмчийн бууралтад цалин, НДШ-ийн өр 39.3 хувиар, дансны өр 54.5 хувиар, татварын өр 0.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн ба хуримтлагдсан алдагдал 3.4 хувиар өсжээ.

“Суат” ХХК-ны Орлогын тайланд хийсэн шинжилгээ

12-р сарын 31, 2019-2021 он

Хүснэгт №08

сая төгрөгөөр

	Сая төгрөгөөр			Эзлэх хувийн жин			Өсөлтийн хувь	
	2019	2020	2021	2019	2020	2021	2018-2019	2019-2020
Борлуулалт								
Борлуулалтын орлого	891.1	923.3	1,197.4	100.0%	100.0%	100.0%	3.6	29.7
Цэвэр борлуулалт	891.1	923.3	1,197.4	100.0%	100.0%	100.0%	3.6	29.7
Борлуулсан барааны өртөг	779.9	781.9	874.2	87.5%	84.7%	73.0%	0.3	11.8
Нийт ашиг	111.2	141.4	323.2	12.5%	15.3%	27.0%	27.2	128.6
Үйл ажиллагааны зардал								
Цалин хөлсний зардал	96.6	112.5	126.1	10.8%	12.2%	10.5%	16.4	12.1
Нийгмийн даатгалын шимтгэл	13.0	15.2	17.6	1.5%	1.6%	1.5%	16.4	16.0
Ашиглалтын зардал	11.3	11.6	16.4	1.3%	1.3%	1.4%	2.8	40.9
Түлш шатахуун, тээврийн зардал	7.3	5.0	7.1	0.8%	0.5%	0.6%	(32.1)	42.8
Түүхий эд материалын зардал	2.0	1.5	2.8	0.2%	0.2%	0.2%	(27.0)	95.0
Элэгдэлийн зардал	204.7	202.5	214.5	23.0%	21.9%	17.9%	(1.1)	5.9
Шуудан холбоо, бичиг хэрэгийн зардал	1.7	1.1	1.3	0.2%	0.1%	0.1%	(33.9)	16.1
Томилолтын зардал	4.5	1.0	0.3	0.5%	0.1%	0.0%	(77.7)	(67.5)
Бусад зардал	14.1	5.3	14.3	1.6%	0.6%	1.2%	(62.2)	168.6
Нийт үйл ажиллагааны зардал	355.4	355.7	400.5	39.9%	38.5%	33.4%	0.1	12.6
Бусад орлого /зардал/			47.7			4.0%		
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагда			1.3			0.1%		
Татварын өмнөх ашиг	(244.2)	(214.4)	(31.0)	-27.4%	-23.2%	-2.6%	(12.2)	(85.6)
Татварын зардал	(24.4)	(21.4)	(3.1)	-2.7%	-2.3%	-0.3%	(12.3)	(85.5)
Татварын дараах цэвэр ашиг	(219.8)	(193.0)	(27.9)	-24.7%	-20.9%	-2.3%	(12.2)	(85.6)

Эх сурвалж: Суат ХХК-д хийсэн аудитын шинжилгээ

Борлуулалтын орлого 2019-2020 онд 3.6 хувиар, 2020-2021 онд 29.7 хувиар өссөн бол үйл ажиллагааны зардал 2019-2020 онд 16.4 хувиар, 2020-2021 онд 12.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны зардал 2019 онд 165.2 сая, 2020 онд 168.1 сая, 2021 онд 184.7 сая төгрөг болж нэмэгдэхэд ажилчдын орон тоо, цалин хөлс нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Үйл ажиллагааны зардлаас цалин, НДШ, ашиглалтын зардлаас бусад бүх зардал 2019-2020 онд 1.1-ээс 77.7 хувь хүртэл буурсан байна. Харин 2020-2021 онд томилолтын зардлын гүйцэтгэл өмнөх оноос 67.5 хувиар буурсан бол бусад бүх зардал 5.9-өөс 95 хувь хүртэл нэмэгдсэн байна.

“Суат” ХХК 2019 онд 219.2 сая төгрөгийн, 2020 онд 193.0 сая төгрөгийн, 2021 онд 27.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Компанийн шинэ байр, Өлгий сумын багуудад татсан цэвэр усны магистрал шинээр ашиглалтад орж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэн нь үйл ажиллагааны зардал нэмэгдэхэд голлон нөлөөлжээ.

Харьцааны шинжилгээ

12-р сарын 31, 2019-2021 он

Хүснэгт №09

сая төгрөгөөр

2019 2020 2021 Дундаж

Төлбөрийн чадварын харьцаа буюу хөрвөх чадварын шинжилгээ

1	Эргэлтийн харьцаа	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө}}{\text{Эргэлтийн эх үүсвэр}}$	0.976	0.634	1.006	0.872
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	$\frac{\text{Бэлэн мөнгө+авлага}}{\text{Эргэлтийн эх үүсвэр}}$	0.672	0.478	0.783	0.644
3	Ажлын цэвэр капитал	ЭХ – ЭЭҮ	-5.14	-123.54	1.70	

Өрийн харьцаа

3	Өрийн харьцаа	$\frac{\text{Нийт өр}}{\text{Нийт хөрөнгө}}$	0.157	0.161	0.157	0.158
4	Өр ба өөрийн хөрөнгийн харьцаа	$\frac{\text{Нийт өр}}{\text{ХНХ}}$	0.186	0.192	0.186	0.188

Ашигт ажиллагааны харьцаа

5	Нийт ахиуц ашиг	$\frac{\text{Нийт ашиг}}{\text{Борлуулалт}}$	-0.247	-0.209	-0.023	-0.160
6	Татварын өмнөх ахиуц ашиг	$\frac{\text{Татварын өмнөх ашиг}}{\text{Борлуулалт}}$	-0.274	-0.232	-0.026	-0.177
7	Активын өгөөж	$\frac{\text{Татварын өмнөх ашиг}}{\text{Нийт хөрөнгө}}$	-0.032	-0.026	-0.004	-0.021
8	Өөрийн хөрөнгийн өгөөж	$\frac{\text{Татварын өмнөх ашиг}}{\text{ХНХ}}$	(0.04)	(0.03)	(0.00)	-0.024

Үйл ажиллагааны харьцаа

9	Авлагын эргэлт	$\frac{\text{Борлуулалт}}{\text{Авлага}}$	6.321	6.083	5.408	5.937
10	Авлага цуглуулах хугацаа	$\frac{365}{\text{Авлагын эргэлт}}$	57.740	60.008	67.498	61.749
11	Өр төлбөрийн эргэлт	$\frac{\text{ББӨ}}{\text{Дансны өр}}$	13.655	9.838	24.171	15.888
12	Төлбөр гүйцэтгэх хугацаа	$\frac{365}{\text{Өр төлбөрийн эргэлт}}$	26.730	37.102	15.101	26.311
13	Нийт хөрөнгийн эргэлт	$\frac{\text{Борлуулалт}}{\text{Нийт хөрөнгө}}$	0.116	0.112	0.147	0.125

Суат ХХК-д хийсэн аудитын шинжилгээ

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн төлбөрийн чадварын харьцаа буюу хөрвөх чадварын, өрийн, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны харьцааны шинжилгээний дүн дараах байдалтай байна.

А. Компанийн төлбөрийн буюу хөрвөх чадварын харьцаанууд 2019-2021 онд дараах байдалтай байна.

- Эргэлтийн харьцааны дундаж 0.8 байгаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгө ашиглан төлөх чадвар муу байна.

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны дундаж 0.6 байна. Энэ үзүүлэлт 1-ээс их байвал төлбөрийн чадвар сайн гэж үздэг тул төлбөрийн чадвар муу байгааг харуулж байна.
- Ажлын цэвэр капитал 2019 онд -5.1 сая төгрөг, 2021 онд -123.5 сая, 2021 онд 1.7 сая төгрөг байгаа нь хөрвөх чадвар муу байгааг харуулж байна.

Б. Өрийн харьцаанууд

- Өрийн харьцаа 2019-2021 онуудад дунджаар 0.1 байна.
- Өр ба өөрийн хөрөнгийн харьцааны дундаж 0.1 байна. Компанийн нийт өр төлбөрийг өмчид хувааж тооцсон ба нийт өр төлбөрийн нэг хэсэг болох үйл ажиллагааны өр төлбөрийг багтаасан тул өр ба хөрөнгийн харьцааны адил энэхүү харьцаа нь компанийн өрийг бүрэн хэмжээгээр хэмждэггүй. Өр төлбөрийг хувь нийлүүлэгчдийн өмчтэй харьцуулах замаар компанийн өрийн байр суурийн тодорхойлоход бага өр ашиглаж, хөрөнгийн байр суурь нь илүү хүчтэй байгааг харуулж байна.

В. Ашигт ажиллагааны харьцаанууд

- Ашигт ажиллагааны хувьд жил дараалан алдагдалтай ажилласан учраас ихэнх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарсан байна. Нийт ахиуц ашгийн харьцааны дундаж -0.1, татварын өмнөх ахиуц ашиг -0.1, активын өгөөж -0.01, өөрийн хөрөнгийн өгөөж 0 хувьтай байгаа нь өөрийн хөрөнгийн өгөөж байхгүй, алдагдалтай ажиллаж байгааг харуулж байна.

Г. Үйл ажиллагааны харьцаанууд

- Авлагын эргэлт 5.9, авлага цуглуулах хугацаа 61.7 байгаа нь авлагын эргэлтийн хурд бага, авлага цуглуулах хугацаа өндөр байгааг харуулж байна.
- Өр төлбөрийн эргэлт гурван жилийн дунджаар 15.9, төлбөр гүйцэтгэх хугацаа 26.3 байгаа нь дансны өрийг /зөвхөн дансны өр/ дунджаар 26 хоногт барагдуулж байгаа үзүүлэлт ба энэ нь дундаж үзүүлэлт юм.

Du Pont загварын шинжилгээ Хүснэгт №10

Он	ROE	Цэвэр ашиг/ Татварын өмнөх ашиг/	Татварын өмнөх ашиг/ Хүү болон татварын өмнөх ашиг	Хүү болон татварын өмнөх ашиг /Борлуулалт	Борлуулалт/ Нийт хөрөнгө	Хөрөнгө/ Эздийн өмч	Нийт хөшүүрэг
		1	2	3	4	5	2*5
2018	(0.03)	0.900	1	-0.2741	0.116	1.19	1.19
2019	(0.03)	0.900	1	-0.2322	0.112	1.19	1.19
2020	(0.00)	0.900	1	-0.0259	0.147	1.19	1.19

Эх сурвалж: Аудитын шинжилгээ

Du pont загвараар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа холбоо, хамаарлыг нэгтгэн үзүүлэхэд 2019-2021 онд компанийн ашигт ажиллагаа,

үйл ажиллагааны түвшин, өрийн түвшинд өөрчлөлт гараагүй байгааг харуулж байгаа бөгөөд компанийн үйл ажиллагаа, үр дүн сайжраагүй байгааг харуулж байна.

ЦШСГ нь техник эдийн засгийн үзүүлэлтийг нийт борлуулалтын орлого, нийт зардал, нийт авлага, өглөг, эргэлтийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө, нийт ажиллагсад, цалингийн сан, дундаж цалин, түгээлтэд авсан цахилгаан, түгээх цахилгааны нийт өртөг, цахилгааны алдагдлын түвшин зэрэг үзүүлэлтүүдээр задруулан төлөвлөгөө гүйцэтгэлийг гаргаж, тайлагнасан байна.

Хүснэгт №11

сая төгрөгөөр

			2019	2020	2021	Дундаж
Төлбөрийн чадварын харьцаа						
1	Эргэлтийн харьцаа	<u>Эргэлтийн хөрөнгө</u> Эргэлтийн эх үүсвэр	112.733	3.980	29.269	48.660
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	<u>Бэлэн мөнгө+авлага</u> Эргэлтийн эх үүсвэр	106.187	3.770	26.333	45.430
Өрийн харьцаа						
3	Өрийн харьцаа	<u>Нийт өр</u> Нийт хөрөнгө	0.220	0.264	0.210	0.231
4	Өр ба өөрийн хөрөнгийн харьцаа	<u>Нийт өр</u> ХНХ	0.283	0.358	0.266	0.302
Ашигт ажиллагааны харьцаа						
5	Нийт ахиуц ашиг	<u>Нийт ашиг</u> Борлуулалт	-0.047	-0.041	0.198	0.036
6	Татварын өмнөх ахиуц ашиг	<u>Татварын өмнөх ашиг</u> Борлуулалт	-0.050	-0.043	0.197	0.035
7	Активын өгөөж	<u>Татварын өмнөх ашиг</u> Нийт хөрөнгө	-0.036	-0.036	0.020	-0.017
8	Өөрийн хөрөнгийн өгөөж	<u>Татварын өмнөх ашиг</u> ХНХ	0.05	0.05	0.03	0.041
Үйл ажиллагааны харьцаа						
9	Авлагын эргэлт	<u>Борлуулалт</u> Авлага	9.591	5.192	7.600	7.461
10	Авлага цуглуулах хугацаа	<u>365</u> Авлагын эргэлт	38.058	70.305	48.026	52.129
11	Өр төлбөрийн эргэлт	<u>ББӨ</u> Дансны өр	2.868	2.425	3.359	2.884
12		365	127.246	150.512	108.660	128.806

	Төлбөр гүйцэтгэх хугацаа	Өр төлбөрийн эргэлт				
13	Нийт хөрөнгийн эргэлт	<u>Борлуулалт</u> Нийт хөрөнгө	88.400	89.800	1.000	59.733

ЦШСГ нь санхүүгийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдээр санхүүгийн шинжилгээг бодитой хийгээгүй, үйл ажиллагаагаа төлөвлөх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.

ЦШСГ-ын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдээр санхүүгийн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

А. Компанийн төлбөрийн буюу хөрвөх чадварын харьцаа 2019-2021 онд дараах байдалтай байна.

- Эргэлтийн харьцааны дундаж 48.6 байгаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгө ашиглан төлөх чадвартай байгааг харуулж байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны дундаж 45.3 байна. Энэ үзүүлэлт 1-ээс их байвал төлбөрийн чадвар сайн гэж үздэг тул төлбөрийн чадвар сайн байгааг харуулж байна.

Б. Өрийн харьцаа:

- Өрийн харьцаа дунджаар 0.2 байгаа нь нийт хөрөнгийн 20 хувь нь өр зээлээр санхүүжиж байгааг харуулж байна.
- Өр ба өөрийн хөрөнгийн харьцааны дундаж 0.3 байна. Богино хугацаат өглөгийг барагдуулах бүрэн чадвартай боловч санхүүгийн тайланд их хэмжээний урт хугацаат өр тайлагнагдаж байгаа нь өр төлөх чадварт нөлөөлсөн байна.

В. Ашигт ажиллагааны харьцаа:

- Жил дараалан алдагдалтай ажиллаж байгаа учраас ихэнх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарчээ. Нийт ахиуц ашгийн харьцааны дундаж 0.036, татварын өмнөх ахиуц ашиг 0.035, активын өгөөж 0.031, өөрийн хөрөнгийн өгөөж 0.037 хувьтай байгаа нь өөрийн хөрөнгийн өгөөж муу байгааг харуулж байна.

Г. Үйл ажиллагааны харьцаанууд

- Авлагын эргэлт 7.5, авлага цуглуулах хугацаа 53.9 байгаа нь авлагын эргэлтийн хурд бага, авлага цуглуулах хугацаанд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.
- Өр төлбөрийн эргэлт гурван жилийн дунджаар 188.7, төлбөр гүйцэтгэх хугацаа 12.5 байгаа нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хурдан хугацаанд төлж байгаа нь нөлөөлж байна гэж үзэх үндэстэй.

Тус үйлдвэрийн газарт Дэлхийн банкны шугамаар 2008 онд хийгдсэн аймгийн төвийн гэр хорооллын 0.4 кт-ын ЦДАШ-ыг сольсон хөрөнгө оруулалтын 2136.6 сая төгрөгийн урт хугацаат өрийг санхүүгийн тайланд тайлагнаж ирсэн байна.

Өлгий, Бугат, Цэнгэл, Толбо, Алтанцөгц сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг үе шаттайгаар Сип кабелиар сольсон нь шугамын алдагдал буурахад нөлөөлсөн байна. Харин хамгийн ихтэй алдагдал Алтай, Баяннуур, Булган, Дэлүүн, Ногооннуур сумууд, Цагааннуур тосгон, Улаан байшинтын алдагдлын хэмжээ 19.6-38.7 хувьтай байгаа нь нийт алдагдалд нөлөөлсөн байна.

2.3.2. Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд санхүүгийн шинжилгээ, үр ашгийн тооцоо хийж, дүгнэж ажиллаагүй байна

“Суат” ХХК нь санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээ хийгээгүй, үр нөлөөг дүгнээгүй байгаа нь компанийн эрх бүхий байгууллагын зүгээс тавих хяналт байхгүй, ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй, гүйцэтгэх захирлын санаачилгагүй, хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

ЦШСГ нь жил бүрийн бизнес, санхүүгийн төлөвлөгөөг хийхдээ эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр санхүүгийн шинжилгээг хийж, үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг дүгнэж ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.3.3. Шууд гэрээгээр худалдаж авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчиж, ашиг сонирхол бүхий гэрээ хийж ирсэн байна

“Суат” ХХК нь их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчил бүхий гэрээ хийгээгүй байна.

Төсөвт байгууллагууд, аж ахуйн нэгж байгууллагуудтай ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ үзүүлэх талаар аж ахуйн харилцааны гэрээ, айл, өрхүүдийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээ байгуулж ажилласан байна.

ЦШСГ нь 2020-2021 онд дараах бараа, материал хөрөнгийг гэрээгээр болон гэрээгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Тухайлбал: 2020 онд “Жайдарман” ХХК-тай Сип кабел худалдаж авах гэрээгээр 44.1 сая төгрөгийн, “Мэйжүрмэнт” ХХК-тай ухаалаг тоолуур худалдан авах гэрээгээр жилийн дүнгээр 61.9 сая төгрөгийн бараа худалдан авч иргэн Эрдэнэбатаас 18.5 сая төгрөгийн сэлбэг, Ховд ЦТС-ээс 18.0 сая төгрөгийн 2 ш трансформатор, Толбо сумын төсөлд иргэн Цолмонбаатараас 37.0 сая төгрөгийн бараа, Отгонсүрэнгээс 19.9 сая төгрөгийн бараа материалыг гэрээ хийхгүйгээр худалдан авчээ.

2021 онд “Жайдарман” ХХК-аас Сип кабел худалдаж авах гэрээгээр 48.2 сая төгрөгийн, “Асгант кент” ХХК-аас нийт 49.4 сая төгрөгийн, “Мэйжүрмэнт” ХХК-иас 77.6 сая төгрөгийн ухаалаг тоолуурыг гэрээгээр худалдаж авсан байна.

Аудитын дүнгээр ЦШСГ-т зөрчил арилгах албан шаардлага өгөв.

2.4. Санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна

2.4.1. Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөөгүй, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна

▪ “Суат” ХХК-ны удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

“Суат” ХХК үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлж танилцуулахаар оруулаагүй, хянуулж, батлуулаагүй байна. Компанийн бизнесийн төлөвлөгөөг баталж албажуулсан талаар шийдвэр байхгүй, ТУЗ нь зөвхөн компанийн бүтэц орон тоо, цалин, урамшуулал, гүйцэтгэх захирлын цалин баталсан тогтоол гаргасан байна.

Компани удирдлагын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг эдийн засагч нь боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулсан боловч удирдлагын зардлыг ямар тооцоо, судалгаанд үндэслэж хийснийг нотлох баримт байхгүй байна.

Компанийн дотоод аудитор нь эдийн засагчийн ажлыг хавсарч ажиллаж байгаа нь компанийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх дотоод аудиторын гүйцэтгэх ажил үүрэгт нь ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байна.

Удирдлагын зардлыг 2019 онд 133.9 сая, 2020 онд 159.4 сая, 2021 онд 151.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Удирдлагын зардлыг 2020 онд өмнөх оны төлөвлөгөөнөөс 25.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 2021 онд 8.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөжээ. Удирдлагын зардал дотор цалин, НДШ-ийн зардал 68.5-72 хувийг эзэлж байгаа ба 2020 онд цалингийн зардлыг 19.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2021 онд 4.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр удирдлагын зардлын төлөвлөгөөг 2019 онд 31.9 сая төгрөгөөр, 2020 онд 8.8 сая төгрөгөөр, 2021 онд 51.6 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Хүснэгт №12

сая төгрөгөөр

№		2019 он		2020 он		2021 он		Төлөвлөгөөг харьцуулахад		Гүйцэтгэлийг харьцуулахад	
		Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	2019-2020	2020-2021	2019-2020	2020-2021
	Нийт зардал	133.9	165.2	159.4	168.2	151.0	202.6	25.5	-8.4	3.0	34.3

Эх сурвалж: Суат ХХК-ны удирдлагын зардлын судалгаа

Зардлын зүйл ангиар авч үзвэл цалин, НДШ-ийн зардлыг 2019 онд 17.8 сая, 2020 онд 13.2 сая, 2021 онд 31.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь хүний нөөцийн менежер, борлуулалтын нягтлан бодогчийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотой боловч төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнийг харуулж байна. Төлөвлөгдөөгүй бусад зардалд 2019 онд 7.2 сая, 2021 онд 5.9 сая төгрөг зарцуулжээ.

Компанийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг 2017, 2022 онуудад шинэчилж, үйл ажиллагааны чиг үүрэгт заасан ажил, үүргийг нэгж, мэргэжилтэн, ажилтнуудад бүрэн хуваарилсан байна. Чиг үүрэгт тусгагдаагүй үүрэг гүйцэтгэсэн асуудал байхгүй байна.

ЦШСГ-ын 2019-2021 оны бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр нэгтгэж харуулав.

Хүснэгт №13 ЦШСГ-ын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	2019 он			2020 он			2021 он			Нийт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт борлуулалтын орлого	7,587.6	8,629.9	1,042.30	10,641.5	9,304.7	-1,336.8	10,413.1	10,556.8	143.70	28,642.2	28,491.4	-150.8
Борлуулалтын орлого	7,454.4	8,558.70	1,104.30	10,576.3	9,233.4	-1,342.9	7,904.9	10,489.8	2,584.90	25,935.6	28,281.9	2,346.3
Үйл ажиллагааны бус орлого	133.2	71.2	-62.00	65.2	71.3	6.10	76.7	67.0	-9.70	275.1	209.5	-65.6
Түгээх үйлчилгээний орлого							2,431.5		-2,431.50	2,431.5	0.0	-2,431.5
Үйл ажиллагааны нийт зардал	7,799.8	8,988.0	1,188.20	10,667.6	9,633.3	-1,034.3	10,670.4	10,773.3	102.90	29,137.8	29,394.6	256.8
Үйл ажиллагааны зардал	1,945.7	1,804.50	-141.20	2,081.9	1,980.8	-101.10	2,217.5	2,231.3	13.80	6,245.1	6,016.6	-228.5
Элэгдлийн зардлын дун	807.3	950.6	143.30	876.3	944.2	67.90	884.9	876.1	-8.80	2,568.5	2,770.9	202.4
Орлогын албан татвараас бусад зардал	5.0	12.0	7.00	6.1	8.0	1.90	6.0	34.5	28.50	17.1	54.5	37.4
Хүүгийн зардал/Урт хугацаат зээл/				366.5		-366.50	-		0.00	366.5	0.0	-366.5
ТЗБАХ-т байгаа байгууллагын ббрийн орлого							214.0		-214.00	214.0	0.0	-214.0
Ажиллагсдын нийгмийн зардал	122.1	53.8	-68.30	141.0	78.9	-62.10	218.1	187.2	-30.90	481.2	319.9	-161.3
Үйл ажиллагааны бус зардал /Цахилгааны өртөг/	4,919.7	6,167.10	1,247.40	7,195.8	6,621.4	-574.40	7,129.9	7,444.2	314.30	19,245.4	20,232.7	987.3
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	-212.2	-358.1		-26.10	-328.6		257.30	-216.50		-495.6	-903.2	

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Цахилгаан шугам сүлжээний газар нь 2019, 2020 оны үйл ажиллагааны орлогын 98.2-99.3 хувийг борлуулалтын орлогоос, 0.7-1.8 хувийг үйл ажиллагааны бус орлогоос оруулахаар, 2021 онд үйл ажиллагааны орлогын 75.9 хувийг борлуулалтын орлогоос, 24.1 хувийг үйл ажиллагааны бус болон түгээх үйлчилгээний орлогоос оруулахаар төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөгөөг 2019 онд 13.7 хувиар, 2021 онд 1.3 хувиар давуулан биелүүлж, 2020 онд 12.6 хувиар тасалсан байна.

ЦШСГ нь 2019 онд 358.1 сая, 2020 онд 328.6 сая, 2021 онд 216.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдал төлөвлөснөөс 2019 онд 145.9 сая төгрөгөөр, 2020 онд 302.5 сая төгрөгөөр, 2021 онд 40.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ.

Захиргааны зардлыг 2019 онд 141.2 сая, 2020 онд 101.2 сая төгрөгөөр хэмнэж, 2021 онд 13.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Зардлын зүйл ангиар авч үзвэл: тээвэр шатахуун, халаалт, конторын хангамжийн зардал, харилцаа холбоо, зар сурталчилгаа, эрүүл мэндийн үзлэг, түрээс, бусад үйлчилгээний хөлс, банкны шимтгэл, үйл ажиллагааны бусад зардлуудыг хэтрүүлж, сэлбэг хэрэгсэл, үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал,

хөдөлмөр хамгааллын зардал, бичиг хэрэг, борлуулалт, маркетингийн зардал, сургалтын зардлуудыг хэмнэж ажилласан байна.

Цахилгаан шугам сүлжээний газар нь 2019-2021 онд төлөвлөгдөөгүй урсгал засвар, дизель станцын халаалт, зар сурталчилгаа, тээврийн зардал, эрүүл мэндийн үзлэг, бусад татвар хураамж зэрэг зардлуудад 50.5-85.9 сая төгрөгийн, нийтдээ 183.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд Цахилгаан шугам сүлжээний газрын удирдлагын үйл ажиллагааны зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй, үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримтлаагүй, санаачилгаагүй ажиллаж ирсэн байна.

Аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулсан, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан байхад байгууллагын орлогод тайлагнаж ажиллаагүй, шатахуун зарцуулалтад тавих хяналтыг сулруулсан, кассаар дамжуулан их хэмжээний худалдан авалт хийдэг, шууд худалдан авах босго үнийн өртгийн дээд хязгаарыг зөрчиж худалдан авалт хийсэн зэрэг зөрчил дутагдал илэрсэн болно.

Аудитын дүнгээр аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019-2021 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр ажиллаж олсон нийт 359.3 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй, “Мэйжүрмент” ХХК-д тооцооноос илүү шилжүүлсэн 45.9 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй бүрдэл дутуу баримтаар зарцуулсан нийт 602.2 сая төгрөгийн, 2019-2021 онд зарцуулсан нийт 248.4 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог хийгээгүй, шатахууны зарцуулалтад зохих ёсоор хяналт тавьж ажиллаагүй зэрэг зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Мөн “Топ тайр” ХХК-д 49.5 сая төгрөг шилжүүлж, санхүүгийн тайлан дахь Булган сумын өглөгт үндэслэлгүй хаасан, Шүүхийн шийдвэрээр Баяннуур сумын Сум хөгжүүлэх сангаас ажлын хөлсөнд авч дансанд орсон 16.7 сая төгрөгийг кассаас өглөг барагдуулах нэрээр нотлох баримтгүйгээр бэлнээр гаргаж авсан зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоов.

2.4.2. Үйл ажиллагааны зардлын төлөвлөлт оновчгүй байна.

- *Үйл ажиллагааны 2019-2021 оны төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар*

“Суат” ХХК-ны гүйцэтгэх удирдлага үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр хянуулж, батлуулаагүй төлөвлөгөө нь оновчтой хийгдсэн гэж үзэх үндэсгүй, энэ нь компанийн 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөлтөд хийсэн судалгаагаар нотлогдож байна.

Үйл ажиллагааны зардлын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт №14

сая төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	2019 он	2020 он	2021 он	Төлөвлөгөөг	Гүйцэтгэл
---	-------------	---------	---------	---------	-------------	-----------

		Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	2019 - 2020	2020 - 2021	2019 - 2020	2020 - 2021
1	Цалин	308.7	336.3	271.5	362.8	364.4	384.0	(37.2)	92.9	26.5	21.2
2	НДШимтгэл	39.6	45.4	39.2	49.0	52.8	55.9	(0.4)	13.6	3.6	6.9
3	ҮХ-ийн элэгдлийн зардал	120.0	190.2	190.1	187.6	187.6	196.3	70.1	(2.5)	(2.6)	8.7
4	Цахилгаан	93.0	144.9	142.5	151.4	151.4	174.2	49.5	8.9	6.5	22.8
5	Дулаан	31.2	13.7	13.7	10.6	24.0	10.0	(17.5)	10.3	(3.1)	(0.6)
6	Түлш, шатахуун, тээврийн зардал	58.8	53.2	43.2	57.4	57.5	52.3	(15.6)	14.3	4.2	(5.1)
7	Холбоо ашиглалт		4.0		3.4		4.0	-	-	(0.6)	0.6
8	Сэлбэг хэрэгсэл		21.6		7.1		13.0	-	-	(14.5)	6.0
9	Урсгал засвар	76.0	16.0	17.5	20.1	20.1	16.3	(58.5)	2.6	4.1	(3.8)
10	Албан томилолт		6.3		1.3	-	-	-	-	(5.0)	(1.3)
11	Газрын төлбөр		-		0.0	-	0.8	-	-	0.0	0.8
12	Сургалтын зардал		2.3	-	1.1	-	0.4	-	-	(1.2)	(0.7)
13	Тоног төхөөрөмжийн зардал		-	-	2.5	-	0.3	-	-	2.5	(2.2)
14	Хангамжийн мат-л	14.7	36.5		16.2	-	12.2	(14.7)	-	(20.3)	(4.0)
15	Хөдөлмөр хамгаалал	9.4	5.8	7.9	7.2	7.1	23.9	(1.5)	(0.8)	1.4	16.7
16	Зар сурталчилгаа	1.5	5.5	5.7	1.8	1.9	1.9	4.2	(3.9)	(3.7)	0.1
17	Бичиг хэргийн зардал		3.9	4.1	4.2	4.8	5.2	4.1	0.7	0.3	1.0
18	бусад	100.5	71.1	282.9	69.1	100.0	112.6	182.4	(182.9)	(2.0)	43.5
19	Хүүгийн зардал	-	-	-	-	-	-	-	-	-	-
20	Түлшний үнийн зөрүү	8.2	4.5	3.0	7.0	7.0	-	(5.2)	4.0	2.5	(7.0)
21	Төрөл бүрийн даатгал		3.8	4.0	3.8	3.8	3.5	4.0	(0.2)	-	(0.3)
22	Төрөл бүрийн татвар	2.7	-	3.0	3.6	3.6	1.2	0.3	0.6	3.6	(2.4)
23	ТУЗ-ын зардал	4.1	5.1	2.5	2.5	2.5	5.3	(1.6)	-	(2.6)	2.8
	Нийт зардал	868.5	970.1	1,030.8	969.4	988.4	1,073.4	162.3	(42.4)	(0.7)	104.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үйл ажиллагааны зардлыг 2019 онд 868.5 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд 2020 онд өмнөх оноос 162.3 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар нэмэгдүүлэн, 2021 онд 2020 оноос 4.1 хувиар буюу 42.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөжээ.

2020 онд цалингийн зардлыг 92.9 сая, түлш, шатахуун, тээврийн зардлыг 15.6 сая төгрөгөөр өмнөх оноос бууруулж төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр цалингийн зардал 91.3 сая төгрөгөөр, түлш шатахуун, тээврийн зардал 14.2 сая төгрөгөөр хэтэрч, бусад зардал 69.1 сая төгрөг хэмнэгдсэн нь төлөвлөлт үндэслэл муутай байгааг харуулж байна.

2021 оны үйл ажиллагааны зардлыг 2020 оны гүйцэтгэлийн түвшинтэй уялдуулж төлөвлөсөн байна.

-Үйл ажиллагааны зардлыг 2019 онд 101.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Цалин 27.6 сая, НДШ-ийн зардал 5.8 сая, элэгдлийн зардал 70.2 сая, цахилгааны зардал 51.9 сая, хангамжийн материалын зардал 21.8 сая, зар сурталчилгааны зардал 4.0 сая, ТУЗ-ийн зардал 1.0 сая төгрөгөөр хэтэрчээ.

Дулааны зардал 17.5 сая, урсгал засварын зардал 60.0 сая, хөдөлмөр хамгааллын зардал 3.6 сая, бусад зардал 29.4 сая, татварын зардал 2.7 сая төгрөгөөр хэмнэгдэж, төлөвлөгдөөгүй холбоо, сэлбэг, албан томилолт, сургалт, бичиг хэрэг, төрөл бүрийн даатгалын зардалд 41.9 сая төгрөг зарцуулжээ.

-Үйл ажиллагааны зардлыг 2020 онд нийт дүнгээр 61.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Цалингийн зардал 91.3 сая, НДШ-ийн зардал 9.8 сая, цахилгааны зардал 8.9 сая, түлш, шатахуун тээврийн зардал 14.2 сая, урсгал засвар 2.6 сая, түлшний үнийн зөрүү 4.0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 2.5 сая, дулааны зардал 2.1 сая, зар сурталчилгааны зардал 3.9 сая, хөдөлмөр хамгааллын зардал 0.6 сая, бусад зардал 213.8 сая төгрөгөөр хэмнэгдэж, төлөвлөгдөөгүй холбоо, сэлбэг, албан томилолт, сургалт, тоног төхөөрөмж, хангамжийн материалын зардалд 31.6 сая төгрөг зарцуулсан байна.

- Үйл ажиллагааны зардлыг 2021 онд нийт дүнгээр 85.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Цалингийн зардал 19.6 сая, НДШ-ийн зардал 3.1 сая, элэгдлийн зардал 8.7 сая, цахилгааны зардал 22.8 сая, хөдөлмөр хамгааллын зардал 16.8 сая, бичиг хэргийн зардал 0.4 сая, бусад зардал 12.6 сая, ТУЗ-ийн зардал 2.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Дулааны зардал 14.0 сая, түлш, шатахуун, тээврийн зардал 5.2 сая, урсгал засварын зардал 3.8 сая, түлшний үнэ 7.0 сая, төрөл бүрийн даатгал 0.3 сая, төрөл бүрийн татварын зардал 2.4 сая төгрөгөөр хэмнэгдэж, төлөвлөгдөөгүй холбоо, сэлбэг, газрын төлбөр, сургалт, тоног төхөөрөмж, хангамжийн материал зардлуудад 30.7 сая төгрөг зарцуулсан байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд үйл ажиллагааны зардлын төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж, үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах талаар санаачилгагүй ажилласан байна.

Ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгоогүй, үйл ажиллагааны зардлын төсөвт тусгаж оны эцэст түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 1998-2001 онуудад хэрэгжсэн “Орон нутгийн хотуудын НАА-г сайжруулах” төсөлд хамрагдаж 1.0 сая долларын хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн тайлан дахь урт хугацаат зээлийн үлдэгдэл 991.0 сая төгрөг байна.

Урт хугацаат зээлийг 2004 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2018 оны 12 дугаар сарын 01-нийг хүртэл хагас жил тутамд сар бүр 53625-аас 40900 доллар төлөх хуваарьтай байна.

Компанийн урт хугацаат зээлийг төлөх талаар санаачилга гаргаж ажиллаагүй, үйл ажиллагааны зардлыг төлөвлөхдөө урт хугацаат зээл, зээлийн хүүгийн төлбөрт төлөх хөрөнгийн эх үүсвэрийг тооцож төлөвлөж байгаагүй байна.

- *Батлагдсан орон тоонд нийцүүлэн цалин урамшууллыг олгож байгаа эсэх талаар*

Компанийн бизнесийн төлөвлөгөө, цалин, урамшууллын хэлбэрийг ТУЗ-өөр батлуулж ажилласан гэх боловч “Суат” ХХК ТУЗ-ийн 2019 оны “2020 оны цалин, урамшууллын хэмжээг баталсан” 02 дугаар тогтоол ирүүлсэн, 2019, 2021 оны бизнесийн төлөвлөгөө, төсөв, цалингийн сан, урамшууллын хэлбэрийг баталсан ТУЗ-ийн шийдвэр байхгүй байна.

Компанийн дүрмийн 7.5-д заасны дагуу шаардлагатай орон тоог батлагдсан цалингийн санд багтаан ажиллуулах үүрэгтэй. 2019, 2021 оны бизнесийн төлөвлөгөө, төсөв, цалингийн сан, урамшууллын хэлбэрийг баталсан ТУЗ-ийн шийдвэр байхгүй байгаа тул гүйцэтгэх захирал ТУЗ-ийн баталсан цалингийн санд багтаан ажиллуулсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Бүтэц орон тоог 2018 оныг суурь түвшин болгон авч үзэхэд 2019 онд 6, 2020 онд 2, 2021 онд 3 орон тоо тус тус нэмэгдэж, 2022 онд 74 орон тоотой болсон байна.

Шаардлагатай орон тоог бий болгох үүднээс байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан хүний нөөцийн менежер, борлуулалтын нягтлан бодогчийн орон тоог 2019 оноос шинээр бий болгож, цэвэрлэх байгууламжийн сахиул, талбайн оператор нарыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд бага давтамжаар ээлжээр ажиллуулахаар талбайн ээлжийн операторын орон тоог 2-оор нэмэгдүүлжээ.

Төв оффис, цэвэр, бохир усны станц, “Рахат” халуун усны цахилгаан хангамжийн хэвийн ажиллагааг хангах, станцын тоног төхөөрөмжийн цахилгаан эрчим хүчний ачаалал, бусад арга зүйг тодорхойлуулж ажиллуулах зорилгоор цахилгааны инженерийн орон тоог 1-ээр нэмсэн байна.

Мөн 2020 онд компанийн дэргэдэх ус шинжилгээний лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс лабораторийн эрхлэгчийн орон тоог бий болгож, Бохир усны 2, 3 дугаар станцын ажилтнуудаас хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа талаар ирсэн гомдлыг шийдвэрлэх үүднээс станцуудыг 4 ээлжээр ажиллуулахаар зохицуулалт хийж орон тоог 3-аар нэмэгдүүлсэн байна.

Цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл өрхийн тоо 2016 онд 1100 байсан нь 2022 онд 2100 болж нэмэгдсэн тул борлуулалтын байцаагчийн болон цэвэр усны шугам сүлжээний слесарийн орон тоог тус бүр 1-ээр нэмэгдүүлжээ.

Харин 2020 оны 1-ээс 6 дугаар сар хүртэл зөвлөхийн орон тоо ажиллуулсан нь шаардлагатай орон тоо биш бөгөөд үр ашиггүй зардал гаргасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 420.0 мянган төгрөг байхаар тогтоосныг мөрдөж, ажилтнуудын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын дүнгээр “Суат” ХХК-д шаардлагагүй орон тоо бий болгож, үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

Цахилгаан шугам сүлжээний газар: ЦШСГ нь цалингийн зардлыг оновчгүй төлөвлөснөөс 2019-2020 онуудад нийтдээ 262.2 сая төгрөгийн хэмнэлтийг үүсгэсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын Удирдах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны бизнес, санхүүгийн төлөвлөгөөнд бүтэц орон тоо, цалин, үр дүнгийн урамшууллын зардлыг баталсан байна. Удирдах зөвлөлийн тогтоолоор 2020 оны 01 дүгээр сараас цалинг 15 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байна. Удирдах зөвлөлийн тогтоолоор 2020 оны 01 дүгээр сараас цалинг 15 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, нэмэгдүүлжээ.

Тус газар нь захиргаа аж ахуй, ашиглалт, засвар, дизель станц, борлуулалт гэсэн 4 хэсэгтэй, нийт 88 орон тоогоор ажилласан байна. Бүтэц орон тоог газрын даргын тушаалаар 2019 онд 85, 2020 онд 86, 2021 онд 90 хүнээр тогтоож, цалингийн жишгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр 2019 онд 3, 2020 онд 2 орон тоогоор илүү, 2021 онд 2 орон тоогоор дутуу ажиллажээ. Цалингийн зардлыг 2019 онд 124.8 сая, 2020 онд 49.9 сая, 2021 онд 87.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хүснэгт № 15

Цалин, урамшууллын зардал, орон тооны судалгаа

Үзүүлэлт	2019 он			2020 он			2021 он		
	Баталгадсан	Гүйцэтгэл	Зөрүү	Баталгадсан	Гүйцэтгэл	Зөрүү	Баталгадсан	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин, урамшуулал	1,277.90	1,153.10	-124.8	1,371.80	1,321.90	-49.9	1,430.10	1,342.60	-87.50
Орон тоо	85	88	3	86	88	2	90	88	-2

/Эх сурвалж: ЦШСГ-ын санхүүгийн тайлангаас/

Цахилгаан шугам сүлжээний газрын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2018 онд хамтын гэрээ байгуулан гэрээг эрх бүхий захиргааны байгууллагаар бүртгүүлсэн бөгөөд гэрээг 2022 онд шинэчлэн байгуулсан байна.

Энэхүү хамтын гэрээний 3.11 дэх заалтад “Ажиллагсад сарын ажлын үр дүнгийн шагналыг албан тушаалын үндсэн /тарифт/ цалингийн 50 хүртэл хувиар олгоно” гэсэн заалтыг үндэслэн ажилчдад сар бүр үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар үр дүнгийн шагнал олгосон байна. Удирдах зөвлөлийн тогтоолоор жилийн үр дүнгийн урамшуулалт цалинд 2019 онд 2.3 сар, 2020 онд 2.2 сар, 2021 онд 2.2 сарын цалингийн хэмжээгээр тус тус олгожээ.

Сарын ажлын үр дүнгийн урамшуулалд 2019 онд 177.4 сая, 2020 онд 209.4 сая, 2021 онд 203.1 сая, нийтдээ 589.9 сая төгрөг, жилийн үр дүнгийн урамшуулалд 2019 онд 94.7 сая төгрөг, 2020 онд 119.7 сая төгрөг, 2021 онд 121.2 сая төгрөг, нийтдээ 335.6 сая төгрөг олгосон байна.

Хамтын гэрээнд заасны дагуу үр дүнгийн урамшуулал олгож байгаа боловч байгууллагын захиргааны зүгээс ажилчдын сарын ажлын үр дүнг үнэлж дүгнэх журам баталж мөрдөөгүй байна.

Ажилчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлыг үнэлж дүгнээгүй, байгууллагын даргад үр дүнгийн урамшууллыг Удирдах зөвлөлөөс шийдвэр гаргуулахгүйгээр олгосон зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

2.4.3. Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагадаа үндэслэж төлөвлөөгүй байна

“Суат” ХХК Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Өлгий сумын 2, 4, 5, 8, 11, 13 дугаар багуудад 2019-2021 онуудад татсан 1,034.1 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон цэвэр усны магистрал шугамыг данс бүртгэлд тусгасан байна. 2021 онд 30.0 сая төгрөгийн үнэ бүхий үйлчилгээний зориулалттай ачааны жийп машиныг хүлээн авсан байна.

Компани нь 2019-2021 онуудад 40.6 сая төгрөгийн 28 тоног төхөөрөмж, 5.4 сая төгрөгийн 11 тавилга, эд хогшил, 3.8 сая төгрөгийн үнэ бүхий борлуулалтын программ, 4.0 сая төгрөгийн санхүүгийн программуудыг хэрэгцээ, шаардлагын дагуу өөрийн хөрөнгөөр худалдаж авсан байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын 2019, 2020, 2021 оны үйл ажиллагааны зардлаас төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын зардал гараагүй байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

3.1. Дотоод аудитын хяналт шалгалт үр нөлөөгүй байна

3.1.1. Орон нутгийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын албанаас хийсэн хяналт хангалтгүй байна

Аймаг дахь Төрийн аудитын газар Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК-ны 2019-2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийж дүгнэлт гаргаж, “зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ. Аудитаар илэрсэн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитын дүнгээр “Суат” ХХК-д нийтдээ 2,297.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,192.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 103.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар зөвлөмжүүдийг өгсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг шалгаж үзэхэд албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч зөвлөмжийн биелэлт 50 хувьтай байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд “Суат” ХХК-ны 2018 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн байна. Аудитаар 22.1 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага өгч, Компанийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах, үргүй зардлыг бууруулж, авлага, өр төлбөрийг барагдуулах, хариуцах эзэн нь тодорхойгүй авлагаас төлөгдөх боломжтой авлагыг барагдуулах, төлөгдөх боломжгүй авлагыг найдваргүй авлагаар бүртгэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх талаар, ТУЗ-өөс компанийн дотоод хяналт, шалгалт хийх журмыг баталж, дотоод аудиторын ажлын төлөвлөгөөг батлах, хийсэн ажлыг хэлэлцэж дүгнэж байх талаар 4 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020, 2021 онд “Суат” ХХК-ны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтаар 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9 зөвлөмжийг өгсөн байна. Төлбөрийн актыг барагдуулсан боловч зөвлөмжийн биелэлтийн талаар баримт материалыг ирүүлээгүй байна.

Аудитын дүнгээр өмнөх онд хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийг арилгаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Аудитын дүнгээр Цахилгаан шугам сүлжээний газарт 2019 онд 292.6 сая төгрөгийн, 2020 онд 351.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, шилэн данстай холбоотой зөрчилд 2020 онд 4,533.2 сая төгрөгийн, 2021 онд 3,594.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг шалгаж үзэхэд шилэн данстай холбоотой зөрчлийг давтан гаргасан байна.

Орон нутгийн өмчийн газар нь ЦШСГ ОНӨҮГ-ын өмч хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 2.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь харьяаллын дагуу орон нутгийн хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаа, өмч хөрөнгийн зарцуулалтад жил бүр хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага боловч энэ үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна

3.2.1. Удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй байна

“Суат” ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн хараат бус гишүүнгүй ба салбар хороо ажиллаагүй байна. Тус компанийн бүтэц орон тоонд 2017 оноос эдийн засагч, дотоод аудиторын орон тоог бий болгож ажиллуулж байгаа ба хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор хангагдаагүй, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор гэж үзэх үндэслэлгүй байна.

Аудитын дүнгээр компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөв.

Цахилгаан шугам сүлжээний газрын Удирдах зөвлөлийн 2016 оны 02 дугаар тогтоолоор дотоод хяналт шинжилгээний ажилтныг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс томилон ажиллуулж, Удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 24-ний 03 дугаар тогтоолоор “Дотоод хяналт шалгалт”-ийн журмыг баталсан байна.

ЦШСГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах төлөвлөгөөг жил бүр Удирдах зөвлөлийн даргаар батлуулсан боловч дотоод хяналт шалгалтын журамд заасан эрх үүргийнхээ дагуу үр дүнтэй хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод хяналт шинжилгээний ажилтан 2019-2021 онд хийсэн ажлын тайлангаа бэлтгэсэн боловч тайлангаа Удирдах зөвлөлд танилцуулж хэлэлцүүлээгүй байна.

Газрын даргын удирдамжаар Алтай, Булган, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Цэнгэл сумуудын борлуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг тооцож ажилласан байна.

3.2.2. Удирдлагын дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна

“Суат” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь 2019-2020 онд компанийн дотоод хяналт шалгалтын нэгжийг 6-8 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна. Компанийн үйл ажиллагаанд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг 2020 онд боловсруулж ТУЗ-ийн даргаар батлуулсан байна.

Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй, хэрэгжилтийг хангуулсан талаар ажлын тайлан байхгүй байна. 2019-2021 онд нийт 10 ажлыг төлөвлөж, 47 зөрчил илрүүлж, зөрчил арилгах давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

“Суат” ХХК-ны гүйцэтгэх удирдлагын зүгээс 2019-2021 онуудад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Дотоод аудитын ажлын төлөвлөгөө баталсан, биелэлтийг албажуулж, үр дүнг хэлэлцсэн талаар баримт материалыг аудитад ирүүлээгүй.

Компанийн удирдлагаас 2019 онд айл өрх, орон сууцны оршин суугчдын судалгаа тооллого хийх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж нийт 13 орон сууц болон 1, 3, 5 дугаар багийн 106 гэр хорооллын айл өрхүүдээр нэг бүрчлэн очиж тооллого хийж, хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тооллогоор айл өрхүүдийн оршин суугчдын тоо болон нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, тоолуураар тооцоо хийдэг айл өрхүүдийн тоолуурын заалтыг нэг бүрчлэн тулгалт хийж заалтыг авч, бүртгэлд ороогүй 36 хэрэглэгчийг илрүүлж шинээр нэмж бүртгэлд оруулан баталгаажуулж, шинээр ашиглалтад орсон орон сууцны айл өрхийн тоолуурын заалтыг баталгаажуулжээ. Мөн төвлөрсөн шугам сүлжээнээс бүртгэлд хамрагдаагүй байсан 25 айл өрхийг бүртгэлд оруулж усны төлбөрийн мэдээллийг илгээх боломжтой болсон байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/768 дугаар захирамжаар байгуулсан усны хэрэглээнд хяналт шалгалт хийх ажлын хэсэг 2020 онд Өлгий сумын нутаг дэвсгэр дэх иргэн, ААН, албан байгууллагуудын усны зүй зохистой хэрэглээнд хяналт тавих, усны алдагдлыг багасгах, тоолууржуулалтыг идэвхжүүлэх, усны үнэ цэнийг таниулан сурталчлах ажлуудыг хийж, шинээр баригдаж буй орон сууцны айл өрхүүдэд барилгын компаниуд дур мэдэн хувь хүмүүсээр усны тоолуур суурилуулж байсан зөрчлийг илрүүлж, арилгуулсан байна.

Компанийн зүгээс техникийн нөхцөл олгохдоо тодорхой заалт оруулж, шаардлага тавих, тухайн барилга байгууламжийг хүлээж авах улсын комиссын

бүрэлдэхүүнд “Суат” ХХК-ны төлөөллийг оруулах арга хэмжээ авсны үр дүнд тухайн зөрчил зохих хэмжээгээр багассан байна.

Компанийн дотоод хяналтын усны шинжилгээний лаборатори нь холбогдох журам, стандартын дагуу төвлөрсөн усан хангамжаас хэрэглэгчдэд түгээж буй ундны ус болон хэрэглээнээс гарч буй бохир усанд сорилт хийж, хяналт тавин ажилласан байна.

Мөн хэрэглэгчийн хүсэлтээр айл өрхүүдийн гар хийцийн худгуудаас ирүүлсэн дээжид үнэ төлбөргүй шинжилгээ хийж, заавар зөвлөгөө өгч, цэвэрлэх байгууламжийн ойролцоо айл өрхүүдийн гар хийцийн худгийн усны болон цэвэрлэх байгууламжийн хөрс, агаарын шинжилгээг аймгийн УЦОШТ-ийн байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэж, зарим аж ахуйн нэгжийн технологийн бохир усанд шинжилгээ хийж гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Химийн бодисын судалгааг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэх, химийн бодис авах ашиглах зөвшөөрөл, сунгуулах, холбогдох стандарт журмын дагуу лабораторийг итгэмжлэлд бэлтгэн оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Лабораторийн сорилт тохируулга баталгаажуулалтад хамрагдах тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, шилэн сав суулгыг аймгийн СХЗХ-ийн улсын шалгагчаар шалгуулж тохируулгад хамруулж гэрчилгээжүүлэх, сорилтын лабораториудын шинжилгээний ур чадварыг хөндлөнгөөс үнэлэх үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын МХЕГ-ын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой “Шинжилгээний ур чадварыг үнэлэх бүдүүвчид хамрагдах тухай гэрээ” байгуулан тус лабораториос зохион байгуулсан хүнсний лабораториудын сорилтын ур чадварыг үнэлэх ээлжит хөтөлбөрт оролцсон байна.

Лаборатори нь цэвэр усанд физик, химийн 14 төрлийн, бохир усанд химийн 10 төрлийн шинжилгээг хийдэг, аймгийн МХГ-ын ХЭА-н хяналтын улсын байцаагчаар тус усны шинжилгээний лабораторийн ажлын байрны эрүүл ахуй, химийн бодисын хадгалалт, хамгаалалтад дүгнэлт гаргуулсан байна.

Бохир усны сүлжээний слесариуд хэрэглэгчдээс ирсэн дуудлага, гэмтлийг барагдуулж ажиллаж, бохир усны гол шугам болон гол шугам дахь 364 ширхэг худгийг лайдаж цэвэрлээд бохир усыг татан зайлуулах үйл ажиллагааг бүрэн хангаж, ажлын хэсэг гарган хяналт, шалгалт хийж ажиллажээ.

Цахилгаан шугам сүлжээний газрын үйл ажиллагааны чиглэл нь үндсэн 4 нэгжид хувааж, нэгжүүд хоорондоо харилцан хамааралтай ажиллахаар зохион байгуулагдсан байна.

Борлуулалтын алба, санхүүгийн албатай хамтран айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийн барагдуулалтыг хариуцаж, тус тусдаа хөтөлж буй программууд нь нэгтгэгдэж, санхүүгийн албыг мэдээллээр хангах түвшинд зохион байгуулагдсан байна

Санхүүгийн программ нь 4 хэсгээс бүрддэг ба “Payable”, “Market indicator”, “cass service” зэрэг хэсгийг борлуулалтын алба нь ашиглаж, хэрэглэгчийн болон борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг оруулж, “Апекс” программд дээрх бүх мэдээллийг татаж, санхүүгийн бусад үйл ажиллагааг оруулж нэгтгэснээр цогц мэдээлэл нэг дор цахимаар гарч, санхүүгийн тайлан гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний бичилт хийх, нэхэмжлэл мэдээлэл хүргэх, цахилгаан эрчим хүчний төлбөрийг барагдуулах үйл ажиллагаанд шат шатандаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Орон сууц, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн цахилгааны тухайн үеийн заалтын бичилтийг оператор-нягтлан бодогч компьютерт оруулж илгээсний дараа борлуулалтын инженер хянадаг бол айл өрхийн хэрэглэгчдийн цахилгааны бичилтийг алсын удирдлагын /ТУГУБ/ багажаар заалт авагчаар авч ирсний дараа оператор, нягтлан бодогч компьютерт уншуулж, борлуулалтын программд холбож борлуулалтын инженер заалт авагч бүрээр бичилтийн цэгийн гүйцэтгэлийн тайлан гаргаж албаны даргад хянуулдаг бол ухаалаг тоолуурын заалтыг IT инженер компьютерээр шууд татаж системд оруулдаг байна.

Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь хэрэглэсэн цахилгааны үнэ төлбөрийг хугацаанд нь төлөөгүй нөхцөлд цахилгааны хязгаарлалт хийж цахилгааны төлбөрийг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа нь борлуулалтын орлого тухайн сард ороход нөлөөлсөн байна.

Аймгийн төвийн Өлгий суманд 2020 онд 380 ширхэг, 2021 онд 391 ширхэг ухаалаг тоолуур тавьж тус системд шилжсэнээр тусгай сервер, программ хангамжтай болсон нь дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд зохих үр дүнгээ өгсөн байна

Сар бүр цахилгаан хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад нэхэмжлэл хүргүүлж, айл өрхийн хэрэглэгчдэд төлбөрийн мэдээллийг хэрэглэгчдийн гар утсанд мессежээр илгээдэг байна. Авлагын мэргэжилтэн өдөр бүр циклийн дагуу төлбөрөө хугацаанд нь төлөөгүй хэрэглэгчдийн жагсаалтыг гаргаж албаны даргаар хянуулж, авлага барагдуулагч нарт цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг Эрчим хүчний тухай хуулийн 32.2.1-д заасны дагуу түр хугацаагаар түдгэлзүүлэн ажилласан байна.

Нөгөө талаар авлагын хэсэг нь долоо хоног бүрийн баасан гаригт цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн хэрэглэгчдийн цахилгаан сүлжээнд байнгын хяналт тавьж ажилласан байна.

Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон хяналт шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтээр тоолуурын ээлжит ба ээлжит бус баталгаажуулалтыг аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран хийж, бүх цахилгаан хэрэглэгчдийн товч, дэлгэрэнгүй мэдээллийг борлуулалтын программаар шууд гаргах боломжтой болжээ.

Цахилгаан хэрэглэгчдийн хэрэглээний мэдээлэл, борлуулалтын үйл ажиллагааны мэдээллийг өдөр, сар, жилээр гаргах боломжтой болсон тул борлуулалтын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтад хүндрэл гарахгүй болж борлуулалтын үйл ажиллагааны хяналт сайжирч зохих үр дүнгээ өгсөн байна.

Харин Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих дотоодын хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс энэ удаагийн гүйцэтгэлийн аудитаар материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ.

Энэ нь байгууллагын удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан, ерөнхий нягтлан бодогч нь 20 дугаар зүйлд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй байгаатай холбоотой байна.

3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангуулж ажиллаагүй

3.3.1 Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаатай байна

“Санхүүгийн тайланд аудит хийлгэхээс өмнө Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, хөрөнгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. “Суат” ХХК Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэлд өгч, тайлангаа Засгийн газрын Э тайлан цахим программд хугацаанд нь шивж оруулсан байна.

Санхүүгийн тайланд аудит хийгдэхээс өмнө Татварын алба, Нийгмийн даатгалын хэлтэстэй татвар, НДШ-ийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээ, судалгааг тухай бүр хүргүүлж байсан байна.

Цахилгаан шугам сүлжээний газар нь санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээ, судалгааг жил бүр Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж ажилласан байна.

Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэлд өгч, тайлангаа Засгийн газрын Э-тайлан цахим программд хугацаанд нь шивж оруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийгдэхээс өмнө аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэстэй татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн талаар тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулдаг байна.

3.3.2. Үйл ажиллагааны мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод, нээлттэй мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

“Суат” ХХК нь 2017-2019 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй хөтөлбөрийн дэмжлэгээр хөгжүүлсэн “Suat.water-mongolia.com” гэсэн вэбсайтыг хөтөлдөг байна. Тус пэйж хуудсанд компанийн танилцуулга, эрхэм зорилго, алсын хараа, зорилтууд, орон тоо, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, холбогдох хууль тогтоомжийн жагсаалт болон цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулсан байна.

Вэбсайтад хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний үнэ тариф, усны тооцоолуур, санал хүсэлт өргөдөл гомдол хүлээн авах, түгээмэл асуулт хариулт, зөвлөмж өгөх булан ажиллуулдаг байна. Тус пэйж хуудаснаас иргэд шууд шилэн дансны мэдээлэлтэй танилцахаар холбосон байна.

Компани нь тус вэбсайтад үйл ажиллагааны тайлан болон, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн талаар мэдээллийг байршуулаагүй байна.

“Суат” ХХК-ны шилэн дансны мэдээллийг аймаг дахь Төрийн аудитын газар жил бүр санхүүгийн тайлангаар аудитаар шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, зөвлөмж өгч ажилласан байна.

Цахим хуудаст мэдээлбэл зохих нийт 28 мэдээллээс 2019 онд 14 мэдээллийг, 2020 онд 15 мэдээллийг, 2021 онд 1 улирлын мэдээллийг оруулаагүй, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт хангагдаагүй, жил бүр зөрчлийг давтан гаргаж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэх үндэстэй байна.

Тус компанийн Шилэн дансны цахим хуудаст зөвхөн батлагдсан төлөвлөгөө гүйцэтгэл, тендерийн ерөнхий мэдээлэл, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээ гүйцэтгэсэн талаар мэдээлэл байршуулах цэс байгаагаас Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Аудитын дүнгээр “Суат” ХХК-нд компанийн вэб сайтад үйл ажиллагааны тайлан болон, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн талаар мэдээллийг байршуулах, шилэн дансны цахим хуудаст зарим мэдээллийг оруулах цэс байхгүй байгааг нээлгэх, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

ЦШСГ-ын орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлтэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцооны хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудитаар шалгалт хийсэн болно.

Гүйцэтгэлийн аудитаар 2019-2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийтдээ 4,794.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Цахилгаан шугам сүлжээний газар нь 2020 онд авлага, өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг бүрэн байршуулаагүй, 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн талаарх 34 гүйлгээний мэдээллийг шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас зарлагын 11 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.

Удирдах зөвлөлөөс тус газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах эрхийг хэрэгжүүлээгүй, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэхүү гүйцэтгэлийн аудитын дүнгээр Баян-Өлгий аймгийн орон нутгийн өмчийн “Суат” ХХК-д нийт 47.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6431.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 8 зөвлөмж өгөв.

Цахилгаан шугам сүлжээний газарт 66.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1772.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 5 зөвлөмж өгөгдлөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт хангагдаагүй байна.
3. “Суат” ХХК нь эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж ажиллаагүй, эрх бүхий байгууллага хянаж, батлаагүй байна.
4. Санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, үр нөлөөг дүгнэж ажиллаагүй байна.
5. Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөөгүй, арвилан хэмнэлттэй зарцуулах талаар хангалтгүй ажилласан байна.
6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн дэргэдэх дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна.
7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт хангалтгүй байна.
8. Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. ЦШСГ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Н.БЕЙБИТХАН-Д

1. Удирдах зөвлөлөөс ЦШСГ-ын бизнес, санхүүгийн төлөвлөгөө, хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр хянаж, тогтоолын хавсралтаар баталж, албажуулж ажиллах;

II. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН-Д

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулахад эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;

III. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Т.НАЗЫМ-Д

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үр ашигтай ажиллуулахад хяналт тавьж, орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах;

2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшнийг оновчтой төлөвлөсөн эсэхийг хянаж, батлах, хэрэгжилтийг хангуулах, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах;

IV."СУАТ" ХХК-НЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ -Д:

1. Компанийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

V."СУАТ" ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.АДАЛБЕК-Д:

1. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож ажиллах;
2. Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж тайлагнаж ажиллах;
3. Компанийн шилэн дансны цахим хуудаст зарим мэдээллийг оруулах цэс байхгүй байгааг нээлгэх, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах;
4. Компаний дүрмийг компанийн тухай хууль, орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэх;

VI. ЦШСГ-ЫН ДАРГА Ж.КЕРЕЙ-Д

1. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож ажиллах;

2. Ажилчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо мөрдөх ажил дүгнэх журам боловсруулан батлуулж мөрдөх, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлж дүгнэн албажуулж байх, Газрын даргад үр дүнгийн урамшуулал олгох асуудлыг Удирдах зөвлөлөөс шийдвэрлүүлж байх;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуульд дараах өөрчлөлтүүдийг оруулах, журам аргачлал батлах талаар Улсын Их Хурал, холбогдох яам, газруудад хүргүүлэхээр санал болгож байна. Үүнд:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуульд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн томъёолж оруулах.

2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх тусгайлсан журам, аргачлал баталж мөрдүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


СУАТ
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“СУАТ” ХХК
83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум
Утас/Факс: (976) 70422112, E-mail: Ulgii_suat@yahoo.com
2022.07.01 67
танай _____ -ны № _____ -т
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус компанийн 3 жилийн үйл ажиллагаанд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайланд танилцсан баямар нэгэн санал хүсэлтгүй болно.

ЗАХИРАЛ  Ж. АДАЛБЕК


20220097



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЦАХИЛГААН ШУГАМ
СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР**

83127 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2714

2022.07.09 № 138
танай _____-ны № _____ - т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН ТАНАА

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын дүнтэй холбоотой саналгүй байгаа болно. Аудитаар өгөгдсөн зөрчил дутагдлыг арилгаж ажиллах болно.

ДАРГА



Ж.КЕРЕЙ

My Documents ЦШСГ Албан тоот-05



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/17

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, "Суат" ХХК, "Цахилгаан шугам сүлжээний газар" ОНӨААҮГ -т тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Х.Бейбитхан, Засаг дарга /Д.Бауыржан/, "Суат" ХХК-ийн захирал Ж.Адалбек, "Цахилгаан шугам сүлжээний газар" ОНӨААҮГ-ын дарга Ж.Керей нарт зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /М.Айнур/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

D:\bichig hereg\2022\tushaal.doc